



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20..... он 01
сарын 05 өдөр

Дугаар 31-1/05

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



000021405188



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20^{д/н} он^{д/н} дугаар
сарын³¹-ны өдөр

Дугаар ...
ХЭТ/3152

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ


000021517103

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 67 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭССЭН нь: “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

УХА0064

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



**“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар байгуулж хангах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг, мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын санаалаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг Монгол Улсын Их Хурал тус тус батлахаар заасан.

Түүнчлэн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Шинэчлэн батлагдсан дээрх хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 53 дугаар захирамжийн 4 дэх заалтаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,

түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсын Их Хурал батлахаар заасан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад үүрэг болгосон.

Иймд "Журам батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно." гэж заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1-д зааснаар тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахгүй болно.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төслийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга-/ийн хэрэгжилтийг нэг мөр хангах зорилгоор боловсруулсан бөгөөд тогтоолын төсөл нь 2 заалттай байна.

Тогтоолын төслийн 1 дэх заалтаар "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам"-ыг 1 дүгээр, "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам"-ыг 2 дугаар, "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус батлахаар, мөн төслийн 2 дахь заалтаар тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Журмын төслүүдэд дараах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана. Үүнд:

1."Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам"-ын төсөлд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулах, иргэдийн санал авах, дүнг мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар;

2."Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам"-ын төсөлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл, эгүүлэн татах асуудлыг санаачлах, эгүүлэн татах санал хураалт зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар;

3."Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ын төслөөр Зөвлөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын засаг захиргаа, нутагдэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилт нэг мөр хангагдах нехцөл бүрдэнэ.

Түүнчлэн, төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй бөгөөд нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй болно.

Дөрөв.Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, тогтоолыг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан хүчингүй болгох хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

-ооОо-

“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг билээ.

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам (§13.3), Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам (§42.2), Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам (§51.3)-ыг тус тус Улсын Их Хурал батлахаар тус тус хуульчилсан.

Түүнчлэн, “Монгол Улсын засаг захиргаа, нутагдэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 53 дугаар захирамжийн 4 дэх заалтаар Монгол Улсын засаг захиргаа, нутагдэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Улсын Их Хурал, Засгийн газар батлахаар заасан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад үүрэг болгосны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Тогтоолын төсөл нь 2 заалттай байна. Тухайлбал, 1 дэх заалтаар “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”-ыг 1 дүгээр, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”-ыг 2 дугаар, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус батлахаар, 2 дахь заалтаар тогтоолын төслийг дагаж мөрдөх хугацааг тусгалаа.

Журмын төслүүдэд дараах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулхаар тусгана. Үүнд:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төсөлд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авах ажлыг зохион

байгуулах, иргэдийн саналын авах, дүнг мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар;

2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журмын төсөлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл, эгүүлэн татах асуудлыг санаачлах, эгүүлэн татах санал хураалт зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар;

3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмын төслөөр Зөвлөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлын талаар зэрэг болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эдгээр эрх зүйн актуудын төслийг тус газрын дэргэдэх “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн дэмжлэгтэйгээр Удирдлагын академийн багш, судлаачдыг татан оролцуулах замаар боловсруулж, журмын төслүүдийг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, Нарийн бичгийн дарга, төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтдийн дунд хэлэлцүүлж, уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналыг зохих журмын дагуу тусган ажиллалаа. Тухайлбал:

- 2021 оны 9 дүгээр сарын 11-17-ны өдрүүдэд Баянхонгор, Увс, Завхан аймгуудад аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, нарийн бичгийн дарга нар болон ажлын албаны ажилтан, албан хаагчдын дунд хэлэлцүүлэг;
- 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдөр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын цахим хэлэлцүүлэг;
- 2021 оны 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, хэлэлцүүлэг /Улаанбаатар хот/;
- 2021 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нарын нэгдсэн уулзалт, хэлэлцүүлэг /Улаанбаатар хот/;
- 2021 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, хэлэлцүүлэг /Улаанбаатар хот/;
- 2021 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарын уулзалт, хэлэлцүүлэг.

Мөн энэ хугацаанд дээрх журмын төслүүдийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн цахим хуудас khural.mn-нд байршуулж, иргэдээс санал авах ажлыг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийн үр нөлөөг үнэлсэн болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаах зардлын тооцоо хийсэн тайланг тус тус Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасны дагуу боловсрууллаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын засаг захиргаа, нутагдэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилт нэг мөр хангагдах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн, төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй бөгөөд нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гаражгүй юм.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

..... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга-/ийн 13 дугаар зүйлийн 13.3, 42 дугаар зүйлийн 42.2, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”-ыг 1 дүгээр, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”-ыг 2 дугаар, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг.

Төсөл

Монгол Улсын Их Хурлын ... оны ... дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН
НЭГЖИЙГ ӨӨРЧЛӨХ АСУУДЛААР ИРГЭДИЙН
САНАЛ АВАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн сонсгалын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг баримтална.

1.3. Аймаг, сум, дүүрэг (цаашид "нэгж" гэх)-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийг өөрчлөхтэй холбоотой баримт бичгийн төсөл боловсруулах, түүнд иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

Хоёр.Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "нэгжийг өөрчлөх" гэж тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалzan улс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинээр байгуулах, нийлүүлэх, хуваах, татан буулгах зэргээр харьялал, нэр, нутаг дэвсгэрийн хэмжээ, хилийн цэсийг шинэчлэн тогтоох, иргэний бүртгэл, кадастрын зураг бүртгэл, хаягийн хөдөлгөөн хийх үйл ажиллагааг;

2.1.2. "нэгжийг шинээр байгуулах" гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдсэн байдлыг үндэслэн зэргэлдээх нэг буюу түүнээс дээш нэгжийн нутаг дэвсгэрээс хуваан олгох замаар нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд шинэ нэгж байгуулахыг;

2.1.3. "нэгжийг нийлүүлэх" гэж хоёр болон түүнээс дээш нэгжийн үйл ажиллагааг зогсоон нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд нэгтгэж, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон нэгжид шилжүүлэхийг;

2.1.4. "нэгжийг хуваах" гэж нэгжийн үйл ажиллагааг зогсоож, түүний нутаг дэвсгэр болон эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш нэгжид олгохыг;

2.1.5. "нэгжийг татан буулгах" гэж бус нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж тухайн нэгжийн үйл ажиллагааг зогсоож, өөр нэгжид (аймаг, сум, дүүрэг)

нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд харьяалуулахыг;

2.1.6.“нэгжийн өөрчлөлтийн төсөл” гэж тухайн орон нутгийн нутаг дэвсгэр (газар, хилийн цэс), хүн ам зүй, газар зүйн байршил, эдийн засгийн бүтэц, төрийн болон нийтийн үйлчилгээний хүртээмж зэргийг тусгасан баримт бичгийг.

Гурав.Нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1.Нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

- 3.1.1.байгаль газар зүй, алслалыг харгалзах;
- 3.1.2.нутаг дэвсгэрийн хувьд давхцахгүй байх;
- 3.1.3.үйлчилгээг дордуулахгүй байх;
- 3.1.4.нутгийн иргэдийг оролцуулах;
- 3.1.5.угсаатан зүй, өв соёлыг хамгаалах;
- 3.1.6.Эдийн засгийн үр ашиг, өгөөжтэй байх.

Дөрөв.Нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах

4.1.Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг нэгжийн өөрчлөлтийн талаарх төсөл боловсруулахад дараахь нөхцөлийг харгалзан үзэж, төслийн баримт бичигт тусгана:

- 4.1.1.харьяалах нэгжийн тоо, харьцаа ойролцоо байх;
- 4.1.2.байгаль, газар зүйн онцлог, алслал болон нутаг дэвсгэрийн хэмжээ зохистой, тэнцвэртэй байх, хилийн цэс тодорхой байх;
- 4.1.3.хүн амын өсөлт, суурьшил, шилжих хөдөлгөөнийг тооцсон байх;
- 4.1.4.зам тээвэр, эрчим хүчний хангамж, усан хангамж, цэвэрлэх болон ариутгалын системүүд стандартын түвшинд байх;
- 4.1.5.төрийн болон орон нутгийн ажил, үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй байх;
- 4.1.6.бусад.

4.2.Нэгжийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачлах бөгөөд төслийн баримт бичгийг энэ журмын 4.1-д заасныг баримтлан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, тухайн нэгжийн төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг боловсруулна.

4.3.Нэгжийн өөрчлөлтийн төсөл, төсвийг боловсруулахад холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд чиг үүргийн дагуу оролцож, уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулна.

4.4.Улсын хилийн дагуух сумыг өөрчлөхтэй холбоотой асуудлаар Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газраас санал заавал авна.

4.5.Нэгжийн өөрчлөлтийн төслийг боловсруулахад эрх ашиг нь хөндөгдөх зэргэлдээх нэгжийн саналыг авна.

Тав.Иргэдийн санал авах үйл ажиллагаа

5.1.Нэгжийн өөрчлөлтийн төслийг тухайн нэгжийн иргэдэд мэдээлэх, танилцуулах, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн үнэлгээ хийх, иргэдээс санал авах, дүнг нэгтгэн мэдээлэх ажлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулна.

5.2.Нөлөөллийн шинжилгээнд нэгжийг өөрчилснөөр гарах үр дагавар, зардлын талаар иргэд болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан саналыг тусгана.

5.3.Энэ журмын 5.1-д заасан арга хэмжээг сум, дүүргийн хувьд 3 сар, аймгийн хувьд 6 сарын хугацаанд тус тус багтаан зохион байгуулна.

5.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нэгжийг өөрчлөх асуудлын талаар иргэдээс өөрчлөлтийг “дэмжиж байна”, “дэмжихгүй” гэсэн томъёоллоор санал авна.

5.5.Санал хураалтад тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцно.

5.6.Өөрчлөлтөд нэг нэгж хамаарах тохиолдолд санал хураалтад оролцсон иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.

5.7.Өөрчлөлтөд хоёр нэгж хамаарч (газар нутаг, хилийн цэс, иргэний харьяалал) байгаа тохиолдолд талуудын саналыг хувь тэнцүүлж тооцно. Хоёр нэгжийн санал хураалтад орох бүртгэлтэй иргэдийн тоог хооронд нь (их, бага) харьцуулж, гарсан дунгээр хүн амын too бага нэгжийн санал өгсөн иргэдийн тоог үржүүлнэ¹. Хоёр нэгжийн тэнцүүлсэн саналын дундаж 50 хувиас дээш бол хүчинтэйд тооцно.

5.8.Нэгжийн өөрчлөлтөд хоёроос олон нэгж зэрэг хамаарч байгаа тохиолдолд санал хураалтыг хоёр, хоёроор болгож, тус тусад нь авч, энэ журмын 5.7-д заасан аргаар тооцно.

5.9.Санал хураах үйл ажиллагаанд ажиглалт хийх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

5.10.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санал хураалтын нэгдсэн дүнг санал хураалтаас хойш 24 цагийн дотор харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

5.11.Нэгжийг өөрчлөх талаар явуулсан иргэдийн санал хураалтын дүн, тайланг ажлын 5 хоногийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Зургаа.Бусад

6.1.Нэгжийг өөрчлөхтэй холбоотой төслийн баримт бичиг боловсруулах, иргэдээс санал авах үйл ажиллагаа болон нэгжийг өөрчилсний дараа гарах улсын

¹Жишээ 1: Аймгийн төвийн сум 15000 хүнтэй, зэргэлдээх сум 3000 хүнтэй бол аймгийн төвийн 1 иргэний саналыг 1; зэргэлдээх сумын 1 иргэний саналыг 5 гэж тооцно.

Жишээ 2: 1-р сум 5500 хүнтэй, 2-р сум 2500 хүнтэй бол 1-р сумын 1 иргэний саналыг 1; 2-р сумын 1 иргэний саналыг 2.2 гэж тооцно.

бүртгэл /иргэний болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, газар зохион байгуулалт, кадастрын бүртгэл, хаяг зэрэг/-ийн өөрчлөлтийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.2.Энэ журмыг зөрчсөн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний төлөөлөгч, Ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

-ооОо-

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын 1 дүгээр хавсралт

НЭГЖИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлт	Нэгж 1		Нэгж 2		Тайлбар
		Одоогийн байдал	Төсөл	Одоогийн байдал	Төсөл	
1.1.	Харьяалал (аймаг, сум, нийслэл, дүүрэг)					
1.2.	Тухайн нэгж (сум, дүүрэг)					
1.3.	Нэгжийн төлөв (аймгийн төв, ердийн, алслагдсан, хилийн, орон нутгийн хот)					
1.4.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй холбогдох асуудал					
1.5.	Өөрчлөлтийн төрөл (шинээр байгуулах, татан буулгах, нийлүүлэх, хуваах)					
1.6.	Нутаг дэвсгэрийн хэмжээ (га-гаар)					
1.7.	Алслагдсан байдал: УБ-аас нэгж хүртэлх зайд Аймгийн төвөөс сум хүртэлх зайд Сумаас багийн төв хүртэлх зайд Хамгийн ойрхон таталцлын төв хүртэлх зайд					
1.8.	Хилийн цэс, зааг (аймаг, сум, дүүргийн хилийн цэс; баг, хорооны нутаг дэвсгэрийн зааг) тогтоосон баримт (шийдвэр, зураг, цэгийн товчоо), төсөл (зураг, цэгийн товчоо), өөрчлөлт хэмжээ					
1.9.	Байгаль орчин Байгалийн бүс, голын ай сав, уул нурууд, нөөц, эх үүсвэр Байгаль хамгаалах үйл ажиллагаа Байгаль орчинд учруулах эрсдэл, түүнээс сэргийлэх					
2.1	Хүн ам зүй Хүн амын тоо, өрхийн тоо (2010, 2020 он) Хүн амын ёсёлтийн хувь Сонгуулийн насны хүний тоо (18+)					
2.2.	Шилжих хөдөлгөөн					

	Ирэх урсгал тоо, хувь Гадагш шилжих тоо, хувь Татах хүчний онцлог Тулхэх хүчний онцлог				
2.3.	Орон нутгийн аж ахуй, үйлдвэрлэл, онцлог (мал аж ахуй; газар тариалан; уул урхай; үйлдвэр,...)				
2.4.	Өрхийн орлогын гол эх Үүсвэр (төрөл тус бүрийн хувь)				
3.1.	Зам тээврийн байдал Хучилттай зам Сайжруулсан зам Төмөр зам				
3.2.	Эрчим хүчний хангамж Төвийн эрчим хүч, чадал Бусад, чадал				
3.3.	Усан хангамж Эх үүсвэр, чанар				
3.4.	Цэвэрлэх байгууламж Ахуйн хатуу хог хаягдлын татан авалт, боловсруулалт Бохир усны систем, ариутгал Үйлдвэрийн хог хаягдлын татан авалт, боловсруулалт, устгал				
4.1.	Эрүүл мэндийн үйлчилгээ Үйлчилгээний байгууллага (сум, баг, өрхийн эмнэлэг, түргэн тусламж) Хамран үйлчлэх хүрээ Үйлчилгээний тоо Орон тоо, төсөв				
4.2.	Боловсрол СӨБ-ийн тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо ЕБС-ийн тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо				
4.3.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Цагдаагийн байгууллагын хүчин чадал, орон тоо Шүүхийн байгууллагын хамрах тойрог Бусад				
4.4.	Нийгмийн бусад үйлчилгээ Гэр бүл, хүүхэд залуучууд Ахмад настан Халамж үйлчилгээ Татвар Нийгмийн даатгал, ЭМД Бусад				
4.5.	Төрийн байгууллагын ажил үйлчилгээтэй				

	холбогдох бүтэц, орон тоо, төсөв (байгууллага тус бүрээр хийж, дунг нэгтгэнэ)					
--	--	--	--	--	--	--

Жич: Тухайн нэгжийн одоогийн нөхцөл байдал, ирээдүйн төсөөлөл бүхий төслийг холбогдох мэргэжлийн агентлаг, байгууллагууд хийж, Ажлын хэсэгт ирүүлэхдээ нэмэлт материалыг хавсаргана.

-ооОо-

Монгол Улсын засаг захиргаа, нутаг
дэвсгэрийн нэгжийг өөрчлөх
асуудлаар иргэдийн санал авах
журмын 2 дугаар хавсралт

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

..... аймгийн сумыг (дүүрэг) шинээр байгуулах, татан
буулгах, нийлүүлэх, хуваах төслийн талаарх санал:

- Дэмжиж байна
- Дэмжихгүй

Он сар өдөр

*Тайлбар: Саналын хуудсанд шинээр байгуулах, татан буулгах, нийлүүлэх,
хуваах гэдгийн аль нэгийг бичнэ.*

-ооОоо-

Улсын Их Хурлын оны дүгээр
тогоолын 2 дугаар хавсралт

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ
СОНГОГЧДЫН САНАЛААР ЭГҮҮЛЭН ТАТАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Энэ журмын зорилго нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (цаашид Хурлын төлөөлөгч гэх)-ийг сонгогчдын саналаар эгүүлэн татахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үйл ажиллагаанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг баримтална.

1.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эрх нь зөвхөн тухайн төлөөлөгчийг сонгосон тойргийн сонгогчдод хадгалагдана.

1.4.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад, түүнчлэн эгүүлэн татахтай холбоотой хууль тогтоомжид нийцсэн аливаа үйл ажиллагаанд тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн оролцох эрхтэй.

1.5.Хурлын төлөөлөгч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа гэж үзвэл тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл болно.

1.6.Хуульд зааснаас өөр үндэслэлээр Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачилж болохгүй.

**Хоёр.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татахад
баримтлах зарчим**

2.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг явуулахад дараах зарчмыг баримтална:

2.1.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж оролцно.

2.1.2.Монгол Улсын иргэн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох нь сайн дурын үндсэн дээр хэрэгжинэ. Хэн ч түүнийг санал хураалтад оролцох буюу эс оролцохыг албадаж болохгүй бөгөөд саналаа өөрөө чөлөөтэй гаргах эрхтэй.

2.1.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг аливаа сонгуулийн санал хураалттай нэгэн зэрэг явуулахыг хориглоно.

2.1.4.Санал хураалтыг бэлтгэх, эрхлэн явуулах, санал тоолох болон санал хураалтын дүн гаргах үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байна.

2.1.5.Санал хураалтын үр дүнд Хурлын төлөөлөгчийг эгүүлэх татах шийдвэр гараагүй бол тухайн төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг 12 сарын туршид дахин явуулахгүй.

2.1.6.Иргэд Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл болон эгүүлэн татах асуудалд хамаарах аливаа үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг олж авах эрхтэй байна.

**Гурав.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах,
сонгогчдын гарын үсэг цуглуулах**

3.1.Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хурлын сонгуулийн нэг тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны иргэдийн 10-аас доошгүй хувь нь гарын үсэг зурж, хамтын санал гарган тухайн тойгоос сонгогдсон Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.

3.2.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах хамтын санал гаргаж, гарын үсгээ зурсан иргэд (цаашид “санаачлагчид” гэх) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санаалаа бичгээр үйлдэж дараахь материалын хамт тухайн нэгжийн Хуралд хүргүүлнэ:

3.2.1.энэ журмын 1.5-т заасан Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэлийг тодорхойлсон холбогдох нотлох баримт;

3.2.2.санаачлагчид дундаасаа томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл;

3.2.3.тухайн гарын үсэг зурж байгаа сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаар;

3.2.4.сонгогчдын гарын үсгийг зуруулах ажлыг зохион байгуулсан үйл явцын тэмдэглэлийг санаачлагчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулсан байх;

3.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал гаргахыг дэмжиж буй сонгогчдын гарын үсгийг цуглуулах ажлыг санаачлагчид хариуцан зохион байгуулна.

3.4.Гарын үсэг зурах үйл ажиллагаатай холбоотой зардлыг санаачлагчид хариуцна.

Дөрөв.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах саналыг шалгах

4.1.Санаачлагчдаас төлөөлөгчийг эгүүлэн татах саналыг Хурал хүлээн аваад 14 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд дараах асуудлыг шалгана:

4.1.1.хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах саналаа Хуралд ирүүлэхдээ тухайн Хурлын төлөөлөгчийн сонгогдсон тойргийн сонгогчдын 10 хувиас багагүй тооны гарын үсэгтэй баримтыг хавсаргасан эсэх;

4.1.2.хурал саналыг хүлээн аваад уг саналын хувийг дагалдах баримт бичгийн хамтаар тухайн Хурлын төлөөлөгчид хүргүүлж, уг саналын үндэслэл бүрээр тайлбар гаргуулах;

4.1.3.энэ журмын 3.9-д заасан гарын үсгийн нэгтгэлийг хүлээн аваад ажлын 5 өдөрт багтаан нийт гарын үсгийн тал хувиас доошгүйг санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн шалгах ба тухайн иргэнтэй уулзах.

4.1.4.гарын үсэг зуруулах ажлыг зөвхөн тухайн төлөөлөгчийн сонгогдсон тойргийн сонгогчдын дунд зохион байгуулсан эсэх.

4.2.Хурал нийт гарын үсгийн 15-аас доошгүй хувь нь хуурамч, эсхүл хүчин төгөлдөр нийт гарын үсгийн тоо нь энэхүү журмын 3.1-д заасан хэмжээнд хүрээгүй бол эгүүлэн татах санал хураалт явуулахаас татгалзана.

Тав.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үйл ажиллагааг зогсоох үндэслэл

5.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үйл ажиллагааг дараах үндэслэлээр зогсоно:

5.1.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан;

5.1.2.Хурлын тухайн төлөөлөгчийн бүрэн эрхийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон;

5.1.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлагчдаас тухайн Хуралд гаргасан хүсэлтийн дагуу эгүүлэн татах үйл ажиллагааг зогсоох тухай холбогдох Хурлын тогтоол гарсан.

Зургаа.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлах

6.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалт явуулахаар саналаа гаргасан иргэдийн гарын үсгийг зуруулах ажил энэ журамд заасны дагуу явагдсан, хүчинтэй гарын үсгийн тоо нь энэ журмын 3.1-д заасан хэмжээнд хүрсэн гэж үзвэл тухайн Хурал гарын үсгийн нэгтгэлийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдөрт багтаан хэлэлцэж, Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураах өдрийг товлон зарлана.

6.2.Санал хураалт товлон зарлах хуралдаанд тухайн Хурлын ёс зүйн асуудал эрхэлсэн хороо асуудлыг өргөн мэдүүлж хэлэлцүүлнэ.

6.3.Санал хураалтыг санал хураалт болох өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө зарлана.

6.4.Санал хураалтыг Ням гарагт явуулна. Санал хураалтыг бүх нийтийн баярын өдөр зохион байгуулахгүй.

6.5.Тухайн Хурал Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг зохион байгуулж явуулах санал хураалтын хороо, хэсгийн хороодыг санал хураалт болох өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

6.6.Тухайн Хурал санал хураах өдрийг товлон зарлаад санаачлагчдын төлөөлөгчид ажлын З өдрийн дотор албан ёсоор мэдэгдэх ба санал хураалт болох талаар тухайн тойргийн сонгогчдод хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлан мэдээлнэ.

Долоо.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох сонгогчдын нэрийн жагсаалтыг

оролцох сонгогчдын нэрийн жагсаалт

7.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох сонгогчдын нэрийн жагсаалтыг санал хураалт болохоос 20-иос доошгүй хоногийн өмнө үйлдэж сонгогчид нэрийн жагсаалтад байгаа өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

7.2.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох сонгогчдын нэрийн жагсаалтыг тухайн төлөөлөгчийн сонгогдсон тойргийн хэмжээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэнэ.

7.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, хүргүүлэх асуудлыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл заасны дагуу зохицуулна.

Найм.Санал хураалтын хороо, санал хураалтын хэсэг, хэсгийн хороо

8.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг зохион байгуулах Санал хураалтын хороог Хурлаас тухайн төлөөлөгчийн сонгогдсон тойротг байгуулж ажиллуулна.

8.2.Санал хураалтын хэсгийг байгуулахаа тухайн Хурлыг сонгох сонгуулийн хэсгийг байгуулсан зарчмыг баримтална. Тухайн хэсэгт явагдах санал хураалтыг зохион байгуулах Хэсгийн хороог тухайн Хурлаас байгуулж ажиллуулна.

8.3.Санал хураалтын хороо нь харьялах тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1.санал хураалт зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

8.3.2.хурлын төлөөлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, санаачлагчдын төлөөлөгчдийг бүртгэх;

8.3.3.санал хураалтын нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх;

8.3.4.санал хураалтын нэгдсэн дүнг тухайн Хуралд өргөн мэдүүлэх;

8.3.5.харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

8.3.6.саналын хуудас болон санал хураалтад ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

8.3.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8.4.Хэсгийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.4.1.хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

8.4.2.санал авах байр, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж /цаашид “санал тоолох төхөөрөмж” гэх/ зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

8.4.3.санал хураалтын дүнг мэдээлэх, нэн даруй дамжуулах;

8.4.4.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Ес.Оролцогч талуудын бүрэн эрх

9.1.Хурлаас төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг дэмжсэн иргэдийн гарын үсэг цуглуулах шийдвэр гарсан өдрөөс эхлэн тухайн төлөөлөгч өөрөө биечлэн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сонгогчдод тайлбар өгөх эрхтэй.

9.2.Санал хураах өдрийг товлон зарласан өдрөөс эхлэн Хурлын төлөөлөгч өөрийн 2 хүртэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулах эрхтэй. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг санал хураалтын хороо уг төлөөлөгчөөс бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн бүртгэж, үнэмлэх олгоно.

9.3.Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг, сонгуулийн эрх бүхий иргэн байна.

9.4.Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн Санал хураалтын хороо, хэсгийн хорооны гишүүн ажиллахыг хориглоно.

9.5.Итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь хуулийн хүрээнд иргэдийг эгүүлэн татахын эсрэг санал өгүүлэх талаар сурталчилгаа хийх, уг төлөөлөгчийг үйл ажиллагааг тайлбарлан таниулах, төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн өмнө төлөөлөгчийг төлөөлөх эрхтэй байна.

9.6.Санал хураах өдрөөс өмнө итгэмжлэгдсэн төлөөлөгчөө тухайн төлөөлөгч эгүүлэн татаж болно. Энэ тухай Санал хураалтын хороонд бичгээр мэдэгдэж, үнэмлэхийг хүчингүйд тооцно.

9.7.Санаачлагчид нь Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарласан өдрөөс эхлэн санал хураах өдрийг хүртэл хугацаанд уг төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл, хүлээлгэх хариуцлагын талаар хуулийн хүрээнд иргэдэд сурталчилгаа хийх эрхтэй.

9.8.Энэ журмын 9.2-т заасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий санаачлагчдын төлөөлөгчдийг Санал хураалтын хороо бүртгэж, үнэмлэх олгоно.

Арав.Санал хураалтын зардлыг санхүүжүүлэх

10.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлах, санал хураалтыг зохион байгуулахтай холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

10.2.Хурлын төлөөлөгчийн болон санаачлагчдын үйл ажиллагааны зардлыг тухайн этгээд өөрөө хариуцна.

10.3.Санаачлагчид Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтын талаар сурталчилгаа хийх зардлаа санхүүжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зардлын данс нээлгэнэ.

10.4.Санаачлагчдын үйл ажиллагааг дэмжиж иргэд, хуулиар хориглоогүй бол хуулийн этгээд хандив өгч болно. Хандив, түүний хэлбэр, хэмжээ, хандивлагч этгээд, бусад зохицуулалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 52, 53, 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

Арван нэг.Санал хураалт зохион байгуулах

11.1.Санал авах байрыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэж, санал авах ажлыг зохион байгуулна.

11.2.Саналын хуудас нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

11.3.Саналын хуудаст уг төлөөлөгчийг эгүүлэн татахыг дэмжиж байгааг болон эгүүлэн татахын эсрэг саналтай байгааг тэмдэглэх боломжтой байна.

11.4.Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах асуудлыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

11.5.Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00-20:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.

11.6.Санал авах ажиллагааг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулна.

11.7.Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах ажиллагааг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

11.8.Сонгогч санал авах байранд биечлэн ирж саналаа өгөх бөгөөд саналаа өгөх ажиллагааг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

11.9.Сонгогч зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх бол “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

11.10.Хурлын төлөөлөгч, санаачлагчид санал авах ажиллагааг санал авах байр бүрт 1 хүртэл ажиглагч томилон ажиллуулж болно.

11.11.Ажиглагчид тавигдах шаардлага, ажиглагчийн эрх, ажиглах үйл ажиллагааг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

**Арван хоёр.Санал хураалтын дүн гаргах, нэгтгэх, мэдээлэх,
дахин санал хураалт явуулах**

12.1.Санал хураалтын дүнг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу хэсэг бүрт гаргана.

12.2.Хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжөөс хэвлэсэн тухайн хэсгийн санал хураалтын дүнг танилцуулсны дараа санал хураалтын дүнгийн хуудсыг холбогдох бусад баримт бичгийн хамт санал хураалтын хороонд нэн даруй хүргүүлнэ.

12.3.Хэсгийн хороо саналын хайрцаг (санал тоолох төхөөрөмж)-аас гарсан саналын хуудас, буцааж хураагдсан саналын хуудас, зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудсыг тус тусад нь тоолон, багцлан боож битүүмжлэн, бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

12.4.Тухайн санал хураалтын хороо хэсгүүдэд явагдсан санал хураалтын дүнгийн нэгтгэлд үндэслэн санал хураалтын нэгдсэн дүнг гаргана.

12.5.Санал хураалтад оролцсон нийт сонгогчдын олонх нь эгүүлэн татахыг дэмжсэн санал өгсөн бол Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татсанд тооцож нийтэд мэдээлнэ.

12.6.Тухайн тойрогт буртгэлтэй сонгогчдын талаас илүү хувь нь санал хураалтад оролцоогүй бол дахин санал хураалт явуулахгүй бөгөөд Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татахыг дэмжээгүйд тооцно.

12.7.Тухайн санал хураалтын хороо санал хураалтын нэгдсэн дүн болон Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эсэх тухай шийдвэрийн төслийг санал хураалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

12.8.Тухайн санал хураалтын хороо дараах тохиолдолд санал хураалтыг хүчингүйд тооцно.

12.8.1.Хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад зарласнаас өөр байранд санал авсан буюу зарласнаас өөр өдөр санал авсан нь санал хураалтын дүнд ноцтой нөлөөлөхөөр бол;

12.8.2.саналын хуудас бүхий зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол.

12.9.Энэ журмын 12.8-д заасан үндэслэлээр санал хураалтыг хүчингүйд тооцсон бол тухайн тойргийн хэмжээнд дахин санал хураалт явуулна.

12.10.Энэ журмын 12.8-д заасан үндэслэлээр санал хураалтыг хүчингүй болгосон нь тухайн ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болсон бол тухайн зөрчил гаргасан албан тушаалтнаар дахин санал хураалт явуулах зардлыг төлүүлнэ.

12.11.Энэ журмын 12.5-д заасны дагуу Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татсанд тооцсон бол тухайн Хурал санал хураалтын нэгдсэн дүнг үндэслэн уг төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татсанд тооцсон тухай тогтоол гаргана.

Арван гурав.Бусад

13.1.Гарын үсэг зурах эсэхээс тухайн сонгогч сайн дурын үндсэн дээр өөрөө шийдвэрлэнэ. Гарын үсэг зурах, эс зурахыг шаардах, албадахыг хориглоно.

13.2.Гарын үсэг зурах, эс зурахад нь нөлөөлөх зорилгоор мөнгө, эд зүйл, бэлэг өгөхийг хориглоно.

13.3.Санал хураалт явуулах үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

13.4.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудалтай холбоотой хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.5.Хурлын Төлөөлөгчийн орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах сонгуулийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.

---оОо---

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан чиг үүрэг бүхий аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалтын бүтцийн нэгж мөн.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандын хууль тогтоомжийг дээдлэн, тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашиг, санал, хүсэлтийг харгалзан хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгоно.

Хоёр.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулах, Зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх

2.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй Зөвлөл байгуулна.

2.2. Зөвлөлийн гишүүнийг улс төрийн нам, эвслийн бүлэг нэр дэвшүүлж, олонхын саналаар 1 /нэг/ жилийн хугацаатай сонгоно. Зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

2.3. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хуралд оролцоогүй тохиолдолд түүнийг Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Гурав.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах

3.1. Зөвлөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

3.1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах талаар холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт чиглэл өгөх;

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид "Зөвлөл" гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан чиг үүрэг бүхий аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалтын бүтцийн нэгж мөн.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаанд хууль тогтоомжийг дээдлэн, тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашиг, санал, хүсэлтийг харгалзан хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулах, Зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх

2.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй Зөвлөл байгуулна.

2.2. Зөвлөлийн гишүүнийг улс төрийн нам, эвслийн бүлэг нэр дэвшүүлж, олонхын саналаар 1 /нэг/ жилийн хугацаатай сонгоно. Зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

2.3. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хуралд оролцоогүй тохиолдолд түүнийг Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах

3.1. Зөвлөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

3.1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах талаар холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт чиглэл өгөх;

3.1.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар Засаг дарга, түүний тамгын газар болон нутгийн захиргааны агентлагийн мэдээлэлтэй танилцах;

3.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн талаар олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлнэ.

**Дөрөв.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны
бэлтгэл хангах**

4.1.Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

4.1.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3-т заасан ээлжит болон ээлжит бус хуралдааны тов, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож Хурлын даргын захирамжаар батлуулах;

4.1.2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.2, 30.2.3, 31.1-д заасны дагуу иргэдийн гаргасан санал, санаачилга, зөвлөмжийг Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

4.1.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс санаачилсан асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж санал өгөх;

4.1.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зөвлөлд ирүүлсэн материалыг хянаж шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас тайлбар, лавлагаа болон бусад материал гаргуулж авах.

**Тав.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн
үйл ажиллагааг уялдуулан зохицуулах**

5.1.Зөвлөл нь Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

5.1.1.Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагаанд зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.1.2.Хурлын хороод, ажлын хэсгийн хэлэлцэх асуудал, тов, хуваарийг тогтоож Хурлын даргаар батлуулах;

5.1.3.Орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар Зөвлөл, Хурлын хороод, ажлын хэсгийн хамтарсан хурал зохион байгуулах;

5.1.4.Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг уялдуулах чиглэлээр санал гаргах.

Зургаа.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

6.1.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна.

6.2.Зөвлөл Хурлын даргын товлосон өдөр, цагт хуралдах бөгөөд Зөвлөл хурлын дэгээ өөрөө тогтооно. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг Хурлын дарга батална.

6.3.Зөвлөлийн хурал гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр байна.

6.4.Зөвлөл үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийн талаар жилд нэг удаа Хурлын хуралдаанд тайлагнана.

6.5.Зөвлөлийн хурлыг Хурлын даргын эзгүйд түүний санал болгосноор аль нэг гишүүн удирдана.

6.6.Зөвлөлийн хурлаас гарах санал нь тэмдэглэл хэлбэртэй байна. Тэмдэглэлд хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.7.Тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж, Хурлын дарга баталгаажуулна.

6.8.Хурлын ажлын алба нь хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө гишүүдэд урьдчилан хүргэж танилцах, санал боловсруулах боломжоор хангах болон Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлөх үүрэгтэй.

6.9.Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн хурлыг цахимаар зохион байгуулж болно.

6.10.Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2021. 12. 31 № 1/5623
танаий _____ -ны № _____ -т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д заасны дагуу "Журам батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлах "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам"-ын төсөл, "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам"-ын төсөл, "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.





МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзандийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn


Вэбсайт:www.mof.gov.mn

02.01.2018 № 6/7243
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ
ТАНАА

Зөвшөөрөл олгох тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгкийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ийн төслийг батлах тухай Улсын Их Хурлын тогтооны төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.



Б.ЖАВХЛАН

9762007178

**“Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын
төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан**

АГУУЛГА	
УДИРТГАЛ	1
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР. ЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	3
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал	3
2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал	4
2.3. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал	4
2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал	4
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	5
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	5
3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	9
3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	13
3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	13
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ	30
4.1. Үр дүнг баримтжуулах	30
4.2. Үнэлэлт, дүгнэлт	30
4.3. Зөвлөмж	36
ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	37

УДИРТГАЛ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Тус хуулийг хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоол батлагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 53 дугаар захирамжаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль, тогтоомжийг нийцүүлэх зорилго бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ гэж тусгасан.

Иймд ажлын хэсгийн захиалгаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу судалгаа, шинжилгээ хийллээ.

Энэхүү судалгааны зорилго нь “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын төслийн /цаашид “журмын төсөл” гэх/ зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, зардал, харилцан уялдаа, үүсэх үр дагавар зэргийг тооцох, эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зэргээр төслийн зохицуулалтыг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхэд оршино.

Журмын төслийн үр нөлөөг үнэлэх үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-ын 1.4-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Журмын төслийн үр нөлөөг тооцохын тулд журмын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан үндсэн шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Зардал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авахдаа дараах үндэслэлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд: “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын төслийн “1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.” гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээ нь журмын төслийн тавьсан зорилгodoо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 онд батлагдсан шинэчилсэн найруулгад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байнгын, тасралтгүй ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын зөвлөл байгуулах тухай заасан. Энэхүү Зөвлөл нь өмнөх хуульд хэрэгжиж байсан Тэргүүлэгчдээс зарчмын ялгаатай бүтэц болохыг тус хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт тусгасан байна. Хуульд зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан аливаа шийдвэр гаргахгүй. Хурлын зөвлөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт зааснаар зөвхөн хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн үүрэгтэйгээр ажиллах юм. Мөн энэ хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эзлжит бус хуралдааныг хуралдуулах санаачлага гаргаж болно гэж зохицуулсан болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал батална гэж тус тус заасан.

Иймд дээрх зорилтод хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт журмын төсөлд тусгагдсан эсэхийг шинжлэнэ.

2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд: Тухайн шалгуур үзүүлэлтийн хувьд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгадаг.

Хууль тогтоомж ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн хуулийн төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан энэ шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хувьд: Журмын төслийн зохицуулалт нь иргэн, аж ахуй нэгж, байгууллага болон улсын төсөвт санхүүгийн ямар ачаалал, эсхүл хөнгөлөлт, хэмнэлт бий болгох, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар зардал үүсэх, зэргийг тооцоолохоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон. Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан тайлан болж гарахыг энд тэмдэглье.

4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хувьд: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажиллах журмын төслийн зүйл, заалт нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авсан.

ХОЁР. ЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ хэсэгт уг журмын төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Зүйл, заалтыг сонгоходоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий зүйл, заалтуудыг сонгон авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгож, тухайн сонгож авсан зүйл, заалтын үр нөлөөг нь судлав.

Түүнчлэн уг журмын төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсэж болохуйц, тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой субъектэд шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хэлтэс, нэгж бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрд авч үзэв. Үүнд:

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал

Журмын төслийн “1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.” гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээг журмын төслөөр тавьсан зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан аливаа шийдвэр гаргахгүй. Хурлын зөвлөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт зааснаар зөвхөн хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн үүрэгтэйгээр ажиллах юм. Мөн энэ хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг хуралдуулах санаачлага гаргаж болно гэж зохицуулсан болно.

Иймд дээрх зорилтод хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт төсөлд тусгагдсан эсэхийг шинжилж дараах зохицуулалтыг сонгон судаллаа. Үүнд журмын

төслийн:

- 3.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна.
- 4.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс өргөн барьсан асуудал, тухайн нэгжийн болон Хурлын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт өгч, уялдуулан зохицуулж, зөвлөн тусална.
- 5.2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 5.3. Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал

Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгадаг.

Хууль ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн хуулийн төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалzan хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийнэ.

2.3. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал

Төслийн улмаас хаана, хэнд ямар хэмжээний зардал үүсч байна гэдгийг нарийвчлан тооцох шаардлагатай бөгөөд энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт болох “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судалж зардлыг тооцно.

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлагдах журмын төслийн зүйл, заалт нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах шалгуураар журмын төслийг бүхэлд нь судлан үзнэ. Үүнд:

1. Журмын төслийн зохицуулалт нь тухайн журмын зорилттойгос нийцэж байгаа эсэх;
2. Журмын төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мэн эсэх;
3. Журмын төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн журмын төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;
4. Журмын төслийн зохицуулалт тухайн журмын төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх;
5. Журмын төслийн зохицуулалт тухайн журмын төслийн болон бусад хуулийн зохицуулалттай давхардсан эсэх;
6. Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

7. Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;
8. Журмын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;
9. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;
10. Татварын хуулиас бусад журмын төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;
11. Тухайн журмын төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;
12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх,
13. Журмын төслийн зохицуулалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх,
14. Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх;
15. Шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;
16. Журмын төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд журмын төсийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тус тус тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойлов.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Журмын төслийн 1 дүгээр зүйлийн 1.1	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Журмын төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар журмын төслийн зохицуулалтуудыг шалгах замаар ойлгомжтой байдлыг шалгах.
3	Зардал	Журмын төслийг бүхэлд нь авч үзнэ.	Зардлын тооцоо хийх
4	Харилцан уялдаа	Журмын төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Журмын төслийн “1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.” гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээг журмын төслөөр тавьсан зорилгодаа хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн

эрхэд хамаарах асуудлаар бие даан аливаа шийдвэр гаргахгүй. Хурлын зөвлөл нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт зааснаар зөвхөн хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн үүрэгтэйгээр ажиллах юм. Мөн энэ хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг хуралдуулах санаачлага гаргаж болно гэж зохицуулсан болно.

Иймд дээрх зорилтод хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт төсөлд тусгагдсан эсэхийг шинжилж дараах зохицуулалтыг сонгон судаллаа. Үүнд журмын төслийн:

- 3.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна.
- 4.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс өргөн барьсан асуудал, тухайн нэгжийн болон Хурлын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт өгч, уялдуулан зохицуулж, зөвлөн тусална.
- 5.2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 5.3. Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хооронд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн." гэж тусгасны дагуу Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2006 онд батлагдсан шинэчилсэн найруулгад Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг ихээхэн өргөн хүрээтэй тодорхойлсон байсан. Энэхүү хуулийн зохицуулалтыг нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн зарчмыг алдагдуулж байна, Тэргүүлэгчид гэх цөөн тооны хүмүүс Хурлын бүрэн эрхийг хурлын чөлөө цагт хэрэгжүүлнэ гэсэн шалтгаанаар Хурлын өмнөөс шийдвэр гаргаж байна, Хурлын хуралдаан жилд 2-3 удаа ёс төдий хуралдаж Тэргүүлэгчдийн урьдчилан хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлыг баталгаажуулдаг байгууллага болсон гэсэн шүүмжлэл, шаардлага Хурлын төлөөлөгчид, судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд тавьж ирсэн гэж Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд дурдсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Хурлын Тэргүүлэгчдийн талаарх заалтыг үгүй болгох, эсхүл тэдгээрийг сонгох шалгуурыг тодорхой болгох. Хурлын Тэргүүлэгчдэд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар өмч, газрын эзэмшил, ашиглалт, үнэ тариф тогтоох гэх мэт Хурлын өөрийнх нь олон чухал эрхийг өгсөн нь цөөн тооны эрх мэдэл бүхий хүмүүс Хурлын өмнөөс шийдвэр гаргахад хүргэж байна¹ гэж Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээнд үзжээ.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтад 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр "Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл,

¹ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УИХ-ын Тамгын газар, НҮБХХ-ийн захиалгаар хийсэн судалгаа, 2016 он.

сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцуулэн хуулиар тогтоож болно." гэж өөрчилсөн. Тодруулбал "...тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн" гэж тусгасан хэсгийг хассан.

Энэ хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 онд батлагдсан шинэчилсэн найруулгад Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл байгуулах тухай заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т зааснаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан аливаа шийдвэр гаргахгүй. Мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т зааснаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь зөвхөн хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн дээрх хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт бүхий зохицуулалт тусгагдсан эсэхийг шалгаж, ач холбогдолтой зохицуулалтыг сонгож авч дүн шинжилгээ хийллээ.

Хуралдааны шийдвэрийн биелэлтийн хангуулах арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах зохицуулалт журмын төслийн гуравдугаар бүлэгт тусгагдсан. Түүнээс голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг журмын төслийн 3.4-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна." гэсэн зохицуулалт байна.

Мөн журмын төслийн 6.5-д "Зөвлөл холбогдох хууль, тогтоомжоор үйлдсэн албан даалгавар, зөвлөмж, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ" гэж зохицуулсан. Албан даалгавар гэдэг нь эрх бүхий албан тушаалтнаас дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор баталсан захирамжилсан баримт бичгийг хэлдэг.²

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.-т "Бүх шатны Засаг дарга тухайн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй." гэж заасан бөгөөд мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1.-т "Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн;" бол Засаг даргад хариуцлага тооцоо зохицуулсан.

Засаг даргад хариуцлага тооцох үндэслэл бий болсон гэж Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь үзэж гарын үсэг зурсан бол Хурал 15 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж, Засаг даргыг огцруулах, эсхүл түүнд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдад нийт төлөөлөгчдийн олонхын саналаар тавьж шийдвэрлүүлэх тухай мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.2-т заажээ.

Хурлын шийдвэрийн биелэлтийг хангалтгүй биелүүлсэн этгээдэд шийдвэрийн биелэлтийг хангуулахаар зөвлөлөөс албан даалгавар гаргах нь Хурлын бүрэн

² Баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт. Монгол Улсын стандарт MNS5140-1 : 2021

эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргасан гэж үзэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иймд тус зохицуулалтыг зорилгод нийцсэн гэж дүгнэхэд учир дутагдалтай бөгөөд "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдалд хуралдааны шийдвэрийн биелэлтийн хангуулах арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийн давхардал болон хууль тогтоомжийн нийцлийг шалгах хэсэгт үүсч буй асуудлыг нарийвчлан тусгасан болно.

Хуралдааны бэлтгэл хангах чиг үүрэг:

- 4.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс өргөн барьсан асуудал, тухайн нэгжийн болон Хурлын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт өгч, уялдуулан зохицуулж, зөвлөн тусална.

Дүгнэлт гэж аливаа үйл ажиллагаа, ажил хэрэг, бодит байдлын явц, үр дүнг тодорхойлсон баримт бичгийг хэлдэг. Харин санал гэж аливаа шийдвэрт тусгах зорилгоор тухайн асуудлаар баримтлах бодлогын талаар санал дэвшүүлсэн баримт бичгийг хэлнэ.³

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл санал, дүгнэлт гаргах тухай хууль болон журамд зохицуулаагүй. Журмын төслийн 6.5-д "Зөвлөл холбогдох хууль, тогтоомжоор үйлдсэн албан даалгавар, зөвлөмж, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ" гэж зохицуулсан.

Иймд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл санал, дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэхээр байна.

Гэсэн хэдий ч журмын дөрөвдүгээр бүлгийн 4.1-4.4 дэх хэсэгт тусгагдсан зохицуулалт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтыг хангаж байгааг дурдах нь зүйтэй.

Хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг:

- 5.2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 5.3. Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11-т "Хурлын хороо болон түр хорооны ажлыг зохицуулан зохион байгуулах, өөрийн дэргэдэх байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах;" бүрэн эрхийг Иргэдийн хурлын Тэргүүлэгчид хэрэгжүүлж байсан. Өмнө дурдсанчлан 2020 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч гэх ойлголт, зохицуулалт байхгүй болсон бөгөөд түүний орон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл хуралдаан хоорондын хугацаанд хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг хуулиар хүлээсэн байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл хурлын хороодын үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг боловсруулж, хурлаар батлуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах тухай зохицуулалт нь журмын төсөлд тусгагдсан зорилгод

³ Баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт. Монгол Улсын стандарт MNS5140-1 : 2021

нийцсэн. Гэсэн хэдий ч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлөөс хурлын хороодод ямар дэмжлэг үзүүлэх зэрэг талаарх шаардлагатай зохицуулалт орхигдсон байна. Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх шалгуурын хүрээнд энэ тухай дэлгэрэнгүй тусгасан тул тухайн хэсгээс дүн шинжилгээг харна уу.

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Журмын төсөл нь Нэг: Нийтлэг үндэслэл. Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоох, сонгох, чөлөөлөх. Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах. Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах. Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт. Долоо: Бусад гэх 7 бүлэг, 46 хэсгээс бүрдэж байх бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийллээ.

Шалгах хуулийн заалт	Хариулт
Хуууль тогтоомжийн тухай хууль	
29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангаагүй.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангаагүй.

29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тэрэл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.

30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангаагүй.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

Дээрх шаардлагыг хангаагүй гэж дүгнэсэн зохицуулалтын тухай судалгааны дараачийн хэсгүүдэд дэлгэрүүлэн тайлбарлья.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам	Шаардлага хангаагүй үндэслэл
2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1. дэх хэсэгт заасан ёсоор аймаг, нийслэл, дүүрэгт 7, суманд 5, аймгийн төвийн болон хүн амын тоо нь 9 001 /есөн мянга нэг/-ээс дээш суманд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй тогтооно гэж зохицуулсан хэсгээс "аймгийн төвийн болон" гэсэн хэсэг нь илүүц болжээ. Зөвлөлийн бүрэлдэхүүн аймагт 7 байх тухай тодорхой заасан тул ойлгомжтой байх үүднээс "аймгийн төвийн болон"	Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих шаардлагыг хангаагүй. Тус хэсэгт аймаг, нийслэл, дүүрэгт 7, суманд 5, аймгийн төвийн болон хүн амын тоо нь 9 001-с дээш суманд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй тогтооно гэж зохицуулсан хэсгээс "аймгийн төвийн болон" гэсэн хэсэг нь илүүц болжээ. Зөвлөлийн бүрэлдэхүүн аймагт 7 байх тухай тодорхой заасан тул ойлгомжтой байх үүднээс "аймгийн төвийн болон"

	гэснийг хасах.
2.3. Аймаг, нийслэл, дүүргийн Зөвлөлийн гишүүнийг улс төрийн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөн нэр дэвшүүлж, олонхын саналаар сонгоно. 2.4. Сумын Зөвлөлийн гишүүнийг төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж, олонхын саналаар сонгоно.	<p>Хэн, хэнийг, ямар арга журмаар сонгох нь тодорхойгүй. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх шаардлагыг хангаагүй.</p> <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, энэхүү журмын төслийг судлахад Зөвлөлийн гишүүн нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч байх тухай зохицуулсан.</p> <p>Иймд тухайн шатны төлөөлөгчдөөс зөвлөлийн гишүүнийг сонгоно гэж логикоор ойлгогдох боловч журамд тусгагдаагүй байна.</p> <p>Мөн зөвлөлийн гишүүнийг сонгох санал хураалтыг илээр эсхүл нууц санал хураалтаар явуулах зэрэг санал авах журмыг тодорхойлоогүй орхигдуулсан байна.</p> <p>Нууц санал хураалт нь төлөөлөгч хэнээс ч хараат бусаар санал өгөх эрхийг баталгаажуулах үндэслэлтэй.</p>
2.7. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хуралд оролцоогүй, Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар чөлөөлөх тухай саналыг хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ;	<p>Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх шаардлагыг хангаагүй.</p> <p>Ямар хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлүүлэх тодорхойгүй. Түүнчлэн зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх зохицуулалтыг бүрэн зохицуулаагүй.</p> <p>Зөвлөлийн гишүүн нь тухайн шатны хурлын төлөөлөгч байх тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т заасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох зохицуулалтын агуулгыг эсхүл уг заалтыг бүрэн ишлэх шаардлагатай байжээ.</p>
Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах. 3.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион	<p>Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн... тодорхой, ойлгоход хялбараар бичих шаардлагыг хангаагүй.</p> <p>Журмын уг зохицуулалтыг хэн хэрэгжүүлэхийг тодорхойлоогүй, эзэн</p>

<p>байгуулах чиглэл холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт өгнө.</p> <p>3.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар Засаг дарга, дэргэдэх агентлагийн удирдлагын мэдээлэл сонсоно.</p> <p>3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дунд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дунг дээшлүүлэх чиглэл өгнө.</p> <p>3.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>3.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн талаар олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлнэ. Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>4.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу ээлжит хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.</p> <p>4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.4. дэх хэсэгт заасны дагуу ээлжит бус хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.</p> <p>Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бүлгийн 5.1-5.5</p> <p>6.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө гишүүдэд урьдчилан хүргэж танилцах, санал, дүгнэлт боловсруулах боломжоор хангана.</p> <p>Долоо. Бусад бүлэг бүхэлдээ.</p>	<p>биегүй зохицуулалтууд тусгасан байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-н Хоёрдугаар бүлгийн 3.4.-т "Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын өгүүлбэрийн бүтэц нь энгийн буюу зэрэгцсэн нийлмэл хэлбэртэй байна. Хуулийн төслийн эх бичвэрийн өгүүлбэр нь нэг бүрэлдэхүүнтэй буюу нэрлэсэн, эсхүл эзэн биегүй байхаас зайлсхийх хэрэгтэй." гэсэн. Иймд уг ажлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл гүйцэтгэх бол түүнийг тодорхой тусгах нь зүйтэй байна.</p> <p>Нөгөө талаас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана." гэж заасан хурлын хорооны чиг үүрэгтэй давхцалтай байж болзошгүй байна.</p> <p>Чиг үүргийн давхцалын тухай журмын төсөлд зөвлөлийн гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх шалгуурын хүрээнд нарийвчлан шалгасан болно. Дүн шинжилгээг тус хэсгээс харна уу.</p>
<p>Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл</p>	<p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын</p>

ажиллагааг уялдуулан зохицуулах 5.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5. дахь хэсэгт заасан журам боловсруулан Хурлын хуралдаанаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавина.	тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5.-т "Хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно." гэж заасан. Зөвлөл нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны ажиллах журмыг боловсруулж хурлаар батлуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, хурлын хороод, ажлын хэсгийн уялдааг хангаж болох боловч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороодын үйл ажиллагааны төлөөвлөгөөг боловсруулж, түүндээ өөрөө хяналт тавих нь зохисгүй юм.
5.2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.	
5.5. Хурлын хороодын ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.	
5.3. Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Ямар дэмжлэг үзүүлэх нь тодорхойгүй. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн... тодорхой, ойлгоход хялбараар бичих шаардлагыг хангаагүй.

Журмын төслийг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.3. "Зардал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу зардлын тооцоо хийх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-р хийсэн тайланд тодорхой тусгасан. Тооцооллыг уг тайлангаас харна уу.

3.4. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажиллах журам"-ын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн "харилцан уялдаа холбоотой байх" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь:

1. Журмын төслийн зохицуулалт нь тухайн журмын төслийн зорилттой нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд:

Журмын төслийн 1.1-т "Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид "Зөвлөл" гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино." гэсэн.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл

байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ." мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал батална." гэж тус тус заасан.

Журмын төсөл нь

- Нэг: Нийтлэг үндэслэл.
- Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоох, сонгох, чөлөөлөх.
- Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах.
- Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах.
- Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт.
- Долоо: Бусад гэх 7 бүлэг, 46 хэсгээс бүрдсэн.

Энэхүү судалгаанд хууль тогтоомжид нийцээгүй гэж дүгнэнээс бусад журмын төслийн зохицуулалт зорилтод нийцэж байна.

2. Журмын төслийн "хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх шалгуурын хүрээнд:

"Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам" төслийн 1.3-т "Зөвлөл нь үйл ажиллагаанд төрийн хууль тогтоомжийг дээдлэхийн зэрэгцээ иргэдийн нийтлэг эрх ашиг, санал хүсэлтийг харгалзан хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгоно." гэж зохицуулсан.

Хуулийн зарчим нь түүний зорилго, агуулгыг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг хөшүүрэг тул хуулийн зүйл, заалтыг хэрэглэхэд эргэлзээ гарсан тохиолдолд асуудлыг тухайн хуулийн зарчмын хүрээнд авч үздэг. Иймд хуулийн зарчмын утyg бүрхэгдүүлсэн цөөн үгээр, эсхүл хэд хэдэн зарчимд хамаарах утyg нэг зарчим болгох, хэтэрхий нуршсан олон үгээр томьёолохоос зайлсхийнэ гэж Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дахь хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 3.3.7-д заасан.

Иймд төрийн хууль тогтоомж гэж байхгүй тул "Монгол Улсын хууль тогтоомж" эсхүл "Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно" гэж зохицуулж болох юм.

3. Журмын төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн журмын төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар нэр томьёо нь олон утгатай эсхүл өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай, мөн шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол нэр томьёоны тайлбар хэрэглэхээр заасан.

Журмын төсөлд нэр томьёоны тайлбар хэрэглээгүй бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь шинээр бий болсон ойлголт хэдий ч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ." гэж зохицуулсан тул дээр тайлбар хэрэглэх шаардлагагүй байна.

Мөн журмын төсөл дэх нэр томьёо нь бусад хуультай зөрчилдсөн, өөр утга

агуулга илэрхийлсэн байдлаар тусгагдаагүй тул энэ шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

4. Журмын төслийн зүйл, заалт тухайн журмын төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд:

Журмын төслийн зүйл заалтууд утга, агуулгын хувьд өөр хоорондоо нийцэж байгаа тул хуулийн төслийн шинэлэг зохицуулалт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлтээр авч үзвэл:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/	Тайлбар
2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1. дэх хэсэгт заасан ёсоор аймаг, нийслэл, дүүрэгт 7, суманд 5, аймгийн төвийн болон хүн амын тоо нь 9 001 /есөн мянга нэг/-ээс дээш суманд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй тогтооно.	51 дүгээр зүйлийн 51.1.-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ...таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна..."	Холбогдох хуульд нийцсэн. Уг хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан байна.
2.9. Зөвлөлийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1. дэх хэсэгт заасан ёсоор тухайн шатны Хурлын дарга тэргүүлнэ.	51 дүгээр зүйлийн 51.1.-т "...Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ." 46 дугаар зүйлийн 46.6-д "Анхдугаар хуралдаанаас бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор төлөөлөгчдийн аль нэг нь удирдана."	Холбогдох хуулийн агуулгад нийцсэн.
6.4. Зөвлөлийн хурлыг Хурлын даргын эзгүйд түүний санал болгосноор аль нэг гишүүн удирдана.	51.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй хэмээн хуульд тусгайлан
3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дунд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг	35 дугаар зүйл. Иргэдийн	

дээшлүүлэх чиглэл өгнө. 3.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна. 7.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд санал, дүгнэлт боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ;	Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 35.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.6.тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх; 35.1.15.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих; 35.1.17.хуульд заасан бусад бүрэн эрх. 41 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох 41.2.Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.	зохицуулсан. Шийдвэр гэж хамтран шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд болон тухайн байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан өөрийн үйл ажиллагаанд болон гадагш чиглэсэн асуудлаар баталсан баримт бичгийг хэлдэг. Санал, дүгнэлт, албан даалгавар гэдэгт юуг ойлгох тухай өмнө дурдсан. Санал, дүгнэлт нь шийдвэр болохгүй хэдий ч тодорхой этгээдэд хариуцлага хүлээлгэх шийдвэрийн үндэслэл болох, дүгнэлтийг захиргааны актад тооцон шүүхэд маргаан хянан шийдвэрлэж буй тохиолдол практик байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн журмын төслийн 6.5-д "Зөвлөл холбогдох хууль, тогтоомжоор үйлдсэн албан даалгавар, зөвлөмж, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ." гэж заасан бөгөөд үүнд санал, дүгнэлт тусгагдаагүй. Санал, дүгнэлт гаргана гэснээр журмын төслийн зохицуулалт хоорондоо болон хуульд нийцээгүй гэж үзэх боломжтой байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны
---	--	--

	<p>бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;</p> <p>43.1.4.асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах.</p>	<p>шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх чиглэл, албан даалгавар гаргах зэрэг журмын төслийн 3.3, 3.4-т заасан нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг зөвлөл өөрийн чиг үүрэгт хамааруулан шийдвэрлэхээр тусгасан гэж дүгнэх боломжтой.</p>
4.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу ээлжит хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.	<p>51.1.... Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.</p> <p>52.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>52.1.1.тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах;</p> <p>52.1.4.эрх бүхий этгээдээс Хурлаар хэлэлцүүлэхээр тавьсан саналыг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын бүрэн эрхэд ээлжит болон зэлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах, шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцэх ажлыг зохион байгуулах тусгагдсан бөгөөд хурлын дарга нь Зөвлөлийг тэргүүлэх тул зөвлөл нь хуралдааны бэлтгэл хангах чиг үүргийн хүрээнд хурлын даргын бүрэн эрхэд тусгагдсан ажлыг гүйцэтгэх боломжтой. Хуульд нийцсэн байна.</p>
4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.4. дэх хэсэгт заасны дагуу ээлжит бус хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.	47.2.-т "Энэ хуулийн 47.1-д заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос ажлын хоёр өдрийн өмнө Хурлын төлөөлөгчдэд тараах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй."	Журмын төслийн тус заалт дахь бусад материал гэдэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47.2-т заасан "тооцоо, судалгаа" хамааруулан
4.6.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зөвлөлд ирүүлсэн материалыг хянаж шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас тайлбар, лавлагаа, бусад материал гаргуулж авна.		

	<p>51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.</p>	<p>оилгохоор байна. Нөгөө талаас зөвлөл хуралдааны бэлтгэл хангах үүднээс хэлэлцүүлэх асуудлын материалын бүрдлийг шалгаж, шаардлагатай тохиолдолд тайлбар, лавлагаа, бусад материал гаргуулж авах эрхтэй байх боловч энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах эрхтэй гэж ойлгож болохгүйг анхаарах нь зүйтэй. Харин хуульд заасан шаардлага хангаагүй асуудлыг хуралд танилцуулж, хурлаас шаардлага хангуулахаар чиглэл зөвлөлд ирсний дагуу холбогдох этгээдээс бусад материалыг шаардах эрхтэй юм.</p>
5.6. Зөвлөлийн гишүүнээр Хурлын хороо, ажлын хэсэг ахлуулж болно.	<p>45.2.Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно.</p> <p>51.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ...таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.</p> <p>39.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй байна:</p>	<p>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл болон хорооны бүрэлдэхүүн нь төлөөлөгчдөөс бүрдэхээр зохицуулсан. Зөвлөл нь Хурлын хороодын үйл ажиллагаа, ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллах чиг үүрэгтэй. Иймд нэг төлөөлөгч зөвлөл болон хурлын хороодод давхар харьяалагдаж, улмаар хурлын хороог ахлах нь ашиг сонирхолын зөрчил үүсгэх нөхцлийг бүрдүүлэх үндэслэлтэй юм.</p>

	39.1.2.Хурлын хороонд харьяалагдах;	Тиймээс зөвлөлийн гишүүн нь давхар хурлын хороонд харьяалагдах боломжийг хязгаарлах зохицуулалт тусгах нь илүү зүйтэй байна.
7.3. Тухайн нэгжид үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Зөвлөл, Хурлын даргын нэр дээр ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариу өгөх, холбогдох байгууллагад шилжүүлнэ.	39.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй байна: 39.1.8.сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах; 52.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 52.1.9.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	Уг зохицуулалт нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч болон хурлын даргын бүрэн эрхийг зөвлөл хэрэгжүүлэх мэтээр зохицуулсан байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийг хурлын дарга тэргүүлэх тухай өмнө дурдсан. Иймд зөвлөл нь гомдлыг хэлэлцэж, хариу өгөх бус ирсэн өргөдөл, гомдлын хариу албан бичгийн төслийг боловсруулах, холбогдох байгууллагад шилжүүлэх саналыг Иргэдийг хурлын даргад гаргах нь зүйтэй юм.

Дээрх хүснэгтээс харахад журмын төслийн Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөл дүгнэлт, албан даалгавар гаргах, өргөдөл, гомдолд хариу өгөх, зөвлөлийн гишүүн хурлын хороо, ажлын хэсгийг ахлахаас бусад журмын төслийн зүйл, заалт хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай нийцэж байна.

5. Журмын төслийн зүйл, заалт тухайн журмын төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй байна.
6. Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгах шалгуурын хүрээнд: Журмын төслийн дараах зохицуулалтууд хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаагүй. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-н Хоёрдугаар бүлгийн 3.4.-т "Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын өгүүлбэрийн бутэц нь энгийн буюу зэрэгцээн нийлмэл хэлбэртэй байна. Хуулийн төслийн эх бичвэрийн өгүүлбэр нь нэг бүрэлдэхүүнтэй буюу нэрлэсэн, эсхүл эзэн биегүй байхаас зайлсхийх хэрэгтэй." гэсэн шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах.

- 3.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт өгнө.

3.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар Засаг дарга, дэргэдэх агентлагийн удирдлагын мэдээлэл сонсоно.

3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх чиглэл өгнө.

3.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна.

3.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн талаар олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлнэ.

Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах.

4.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу ээлжит хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.

4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.4. дэх хэсэгт заасны дагуу ээлжит бус хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.

Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

5.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5. дахь хэсэгт заасан журам боловсруулан Хурлын хуралдаанаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

5.2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.3. Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

5.4. Хурлын хороодын үйл ажиллагаатай холбоотой зардлыг хурлын төсөвт тусгаж хуралдаанаар батлуулна.

5.5. Хурлын хороодын ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж хуралдаанаар хэлэлцүүлнэ.

6.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө гишүүдэд урьдчилан хүргэж танилцах, санал, дүгнэлт боловсруулах боломжоор хангана.

Долоо. Бусад

7.1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах асуудлаар Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх агентлагийн удирдлагад асуулга тавих, түүний хариуг хэлэлцэж санал, зөвлөмж, өгөх шаардлагатай тохиолдолд хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.2. Нутаг дэвсгэртээ төрийн хууль тогтоомж, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг тайлбарлан таниулах, сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах асуудлаар Засаг даргад асуулга тавьж, хуралдаанд танилцуулна.

7.3. Тухайн нэгжид үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Зөвлөл, Хурлын даргын нэр дээр ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариу өгөх, холбогдох байгууллагад шилжүүлнэ.

7.4. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.

7.5. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой зардлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт тусган хуралдаанаар батлуулна.

7.6. Тухайн нэгжид оршин суугаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас орон нутгийн хөгжлийг дэмжих, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр, нийгмийн хариуцлагын хүрээнд гаргасан аливаа үүсгэл санаачилгыг хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.7. Хурлын төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг шуурхай гаргуулахад анхаарч шаардлагатай тохиолдолд хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд санал, дүгнэлт боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ;

Журам нь Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн ажиллах журам хэдий ч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн чиг үүрэг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо, Засаг даргын Тамгын газрын чиг үүрэгтэй тодорхой хэмжээгээр давхцаж байгааг анхаарч дээрх ажлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл гүйцэтгэх бол түүнийг тодорхой, эзэн биеийг нэрлэн зааж тусгах нь зүйтэй байна.

7. Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх шалгуурын хүрээнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Тайлбар
2.3. Аймаг, нийслэл, дүүргийн Зөвлөлийн гишүүнийг улс төрийн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцэн нэр дэвшүүлж, олонхын саналаар сонгоно.	Хуульд энэ тухай зохицуулалт тусгагдаагүй.	Хэн, хэнийг, ямар арга журмаар сонгох нь тодорхойгүй. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Зөвлөлийн гишүүн нь тухайн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч байх тухай зохицуулсан. Иймд тухайн шатны төлөөлөгчдөөс зөвлөлийн гишүүнийг сонгоно гэж логикоор ойлгогдох боловч журамд тодорхой
2.4. Сумын Зөвлөлийн гишүүнийг төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж, олонхын саналаар сонгоно.		

		тусгагдаагүй байна. Мөн зөвлөлийн гишүүнийг сонгох санал хураалтыг илээр эсхүл нууц санал хураалтаар явуулах зэрэг санал авах жurmыг тодорхойлоогүй орхигдуулсан байна.
2.7. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хуралд оролцоогүй, Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар чөлөөлөх тухай саналыг хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ;	41 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох 41.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дараах үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болно: 41.1.1.нас барсан; 41.1.2.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан; 41.1.3.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтооолоор батлагдсан; 41.1.4.тухайн орон нутгаас шилжсэн; 41.1.5.энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон; 41.1.6.энэ хуулийн 40.1-д заасныг зөрчсөн; 41.1.7.Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн; 41.1.8.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үндэслэлээр төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр хүчингүй болсон.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т зааснаар зөвлөлийн гишүүн нь иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч байх тул хурлын төлөөлөгчдийн бүрэн эрх дуусгавар болох агуулга нь зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх зохицуулалтад бүрэн тусгагдсан байх шаардлагатай. Төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох зохицуулалтаас зөвхөн хурлын төлөөлөгч ёс зүйн дүрмийг зөрчсөн үндэслэлийг тусгасан, бусад үндэслэлийг орхигдуулсан байна.
	38.5.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь үйл ажиллагаандaa баримтлах ёс зүйн дүрэмтэй байх	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг

	бөгөөд ёс зүйн дүрмийг Хурал батална.	зохион байгуулах чиг үүргийн хүрээнд хурлаар батлагдах ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан, хурлаар батлуулах боломжтой. Энэ тухай зохицуулалт журамд тусгагдаагүй байна.
2.8. Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болох ба урамшуулал олгох журмыг тухайн хурал батална.	55.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна. 55.2.Энэ хуулийн 55.1-д заасан төсөв нь Хурлын үйл ажиллагааны болон ажлын албаны төсвөөс бүрдэнэ.	Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь төсөвтэй байх бөгөөд төсөв нь үйл ажиллагааны төсвөөс бүрдэж байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа гэдэгт зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарах тул урамшууллын санхүүжилтийг хурлын төсвөөс гаргах боломжтой юм.
3.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн талаар олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлнэ.	39.3.Хурлын төлөөлөгч нь хуралдааны чөлөөт цагт Хурлын хорооны үйл ажиллагаанд оролцож, төлөөлөгчийн хувьд хийсэн ажлынхаа талаарх мэдээллийг Хурлын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр сонгогчдод мэдээлнэ.	Ямар хэлбэрээр мэдээллэх тухай зохицуулаагүй орхигдуулсан. Иймд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасантай адилаар цахим хуудсаар болон бусад хэлбэрээр мэдээлнэ гэж тусгах.
6.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө гишүүдэд урьдчилан хүргэж танилцах, санал, дүгнэлт боловсруулах		Хэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй. Зөвлөл нь өөрийн ажлын алба, нарийн бичигтэй байх эсэх зохицуулалт хууль болон журмын төсөлд тусгагдаагүй.

боловжоор хангана.

Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартид сонгогдсон төлөөлөгчдөд бүрэн эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх бололцоо олгох тухай заагаад (7.1), үүргээ гүйцэтгэх хугацаанд гаргасан зардлын зэрэгцээ төлөөлөгчөөр сонгогдон ажилласан хугацаанд алдсан орлого, нийгмийн даатгалын төлбөрийг нь нөхөн олгох, төлөөлөгчийн хувьд гүйцэтгэсэн ажилтай нь дүйцсэн урамшуулалт олгож байх тухай заажээ (7.2). Төлөөлөгчдийн цалин, урамшууллын асуудлыг улс орнууд янз бүрээр зохицуулсан байна.

Жишээлбэл, Германд төлөөллийн байгууллагад сонгуульт үүрэг хүлээхийг сайн дурын ажил гэж үзэж ирсэн учраас шууд хориглодог, Литвад төлөөлөгчийн үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулсан цагт нь тохирсон цалин олгодог, Хорватад цалин авахыг хориглосон хэрнээ төлөөлөгчийн үүргээ гүйцэтгэхэд гарсан зардлыг нь нөхөн олговор байдлаар олгодог байна.⁴

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.11-д "Иргэдийн нийтийн хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсөөвөс олгож болно", 44 дүгээр зүйлийн 44.2. "Хурлын төсөөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална." гэж тус тус заасан.

Иймд төлөөлөгч зөвлөлийн гишүүнээр ажиллах тохиолдолд түүнд олгох урамшууллыг хурлын төсөөвт тусгаж, санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой гэж харж байна.

Мөн зөвлөл нь хурлын бэлтгэлийг хангах арга хэмжээ зохион байгуулах чиг үүргийн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлах /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны дэг зэрэг/ нийт төлөөлөгч нарт хамаарах дүрэм, журмын төслийг боловсруулж хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах тухай зохицуулалт нэмж, тусгах шаардлагатай. Энэ талаарх зохицуулалт орхигдажээ.

Дээрх дурдсан үндэслэлүүдийг анхаарч журмын төсөлд орхигдуулсан зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэмж тусгах шаардлагатай байна.

8. Журмын төсөлд зөвлөлийн гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх шалгуурын хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчилсэн найруулгыг судлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Тайлбар
1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр	45.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах,	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын

⁴ 2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. УБ., 2019 он. 70 дахь тал.

<p>зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино.</p>	<p>Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.</p> <p>52.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>ажлын албаны хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны шийдвэрийн биелэлтийн хангуулах, хянан шалгах чиг үүрэг давхцалтай мэт харагдаж байх боловч дараах байдлаар зарчмын ялгаатай байгааг анхаарах шаардлагатай байна. Үүнд:</p> <p>Зөвлөл нь:</p> <ul style="list-style-type: none"> - Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах; - Хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах; - Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах. <p>Хороо нь:</p> <ul style="list-style-type: none"> - Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах; - Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; <p>Ажлын алба⁵:</p> <ul style="list-style-type: none"> - Хурлын хуралдааны бэлтгэл хангах; - Тэмдэглэл хөтлөх, тогтоол, шийдвэрийн төслийг бэлтгэх; - Төлөөлөгчид, хороод, зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; - Хурлын төсвийг
<p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл</p> <p>51.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.</p>	<p>52.1.2.тухайн Хурлын хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>52.1.4.эрх бүхий этгээдээс Хурлаар хэлэлцүүлэхээр тавьсан саналыг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>52.1.5.Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;</p>	
<p>51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.</p>		

⁵ Хамтын бүтээл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн албан бус тайлбар. УБ., 2020 он.

		<p>- захиран зарцуулах;</p> <p>- Хурлын бичиг хэргийг хөтлөх зэрэг;</p>
3.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт өгнө.	45.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулна гэж заасан. Үүний дагуу хурал бүр тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэгтэй хороо байгуулахаар байна.	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 45.1-т зааснаар Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хурлын хороо байгуулан ажиллуулна гэж заасан. Үүний дагуу хурал бүр тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэгтэй хороо байгуулахаар байна.
3.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх чиглэл өгнө.	52.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 52.1.5.Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;	Журмын төслийн 3.1-т заасан хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах,
3.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна.	67.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ: 67.1.4.хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох; 65.1.Засаг даргад дараах үндэслэлээр хариуцлага тооцно: 65.1.1.Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн;	эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороонд өгөх боломжтой. Гэсэн хэдий ч Журмын төслийн 3.3, 3.4-т зааснаар хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, түүний дээшлүүлэх чиглэл болон албан даалгавар гаргаж хэрэгжилтийг зохион байгуулах нь Тус хорооны болон Засаг даргын Тамгын газрын чиг үүрэгтэй давхцаж байна.

	санаачлан хэлэлцүүлэхээр эрхтэй.	Хуралд оруулах	Иймд зөвлөл нь шийдвэрийн биелэлтийг хангуулах чиг үүргийн хүрээнд бие даан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, чиглэл албан даалгавар гаргах нь хуульд нийцэхгүй. Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргийн хорооноос шалгалт хийж, шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн этгээдэд хариуцлага ногдуулах асуудлыг хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал оруулж, шийдвэрлүүлнэ. Мөн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргаас ирсэн чиглэл, үүрэг даалгаврын хүрээнд шийдвэрийн биелэлт хангуулах арга хэмжээг зохион байгуулах болохыг анхаарах шаардлагатай байна. Арга хэмжээ зохион байгуулах гэдэгт хянан шалгах хамааралгүйг анхаарах нь зүйтэй.
4.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс өргөн барьсан асуудал, тухайн нэгжийн болон Хурлын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж	45.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.	45.4.Хурал нь судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий бусад хороо,	Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн хурлаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт өгөх зохицуулалт нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороонд судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий хороо,

<p>санал дүгнэлт өгч, уялдуулан зохицуулж, зөвлөн тусална.</p>	<p>ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.</p> <p>51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.</p>	<p>ажлын хэсгийн ажлын чиг үүрэгтэй давхацсан.</p> <p>Хуралдааны бэлтгэл хангах чиг үүргийн хүрээнд Хороо нь хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах ажлыг хариуцна. Харин зөвлөл нь хурлын даргаар тэргүүлүүлэх учир хурлын даргын зөвлөлд өгсөн үүрэг даалгаврын дагуу хуралдааныг товлон зарлах, хэлэлцэх асуудлыг эрэмбэлэх, хурлын хороодуудад хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэхийг мэдэгдэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой юм.</p>
--	--	--

Дээрх хүснэгтээс дүгнэхэд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах талаарх журмын төслийн 3.3, 3.4, хуралдааны бэлтгэл хангах тухай журмын төслийн 4.5-д заасан зохицуулалт нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо болон Засаг даргын тамгын газрын чиг үүрэгтэй давхацсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцийг авч үзвэл:

**Иргэдийн төлөөлөгчдийн
хурал**



Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь шийдвэр гаргахгүйгээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ерөнхий менежмент, зохион байгуулалтыг хариуцаж ажиллахаар байна. Үүнтэй төстэй бүтэц Япон Улсын Токио хотын нутгийн удирдлагын бүтцэд тусгагдсан байдаг. Манай улсын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зохион байгуулалтын бүтцээс ялгарах онцлог нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ерөнхий менежмент, зохион байгуулалтыг хариуцсан зөвлөл бус хороо байгуулдаг байдлаар онцлог байна.

9. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажлын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт хамааруулаагүй байна.

10. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх шалгуурын хүрээнд хуулийн төслийг судлан үзэхэд шинээр тусгай зөвшөөрөл олгох талаар зохицуулалт агуулаагүй байна.
11. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан эсэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, авлига, хүнд суртал, шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд судлан үзэхэд шалгуурыг хангасан байна.
12. Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийг судлан үзлээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой дагалдан гарах бусад хуульд Зөрчлийн тухай хууль багтаагүй. Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлагдах "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам"-д зөрчилд холбогдох зохицуулалт агуулаагүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасны дагуу үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үеийг дараах 3 үе шатын дагуу явууллаа.

Нэгдүгээр үе шат: Үр дүнг баримтжуулах;
Хоёрдугаар үе шат: Үнэлэлт, дүгнэлт өгөх;
Гуравдугаар үе шат: Зөвлөмж өгөх.

4.1. Үр дүнг баримтжуулах

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд хавсаргалаа. Үнд:

"Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан үндэслэл болсон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-н холбогдох заалт;

"Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам"-ын төслийн үзэл баримтлал, журмын төсөл;

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга;

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа.

4.2. Үнэлэлт, дүгнэлт

Журмын төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 4 үе шатаар 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийж, үр нөлөөг үнэллээ.

1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Журмын төслийн "1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн (цаашид "Зөвлөл" гэх) үйл ажиллагааг зохицуулахад оршино." гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээг журмын төслөөр тавьсан зорилгodoо хүрч чадах эсэхийг журмын төсөлд тусгагдсан зохицуулалтад голлох ач холбогдол бүхий зүйл заалтыг сонгож судалсан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т зааснаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан аливаа шийдвэр гаргахгүй. Харин Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх тухай мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасан.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах арга хэмжээ зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт журмын төслийн гурав, дөрөв, тав дугаар бүлгүүдэд тус тус тусгагдсан.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах арга хэмжээг зохион байгуулах тухай зохицуулсан журмын төслийн 3.3 болон 3.4 дэх зохицуулалт нь чиг үүргийн хувьд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороотой давхцалтай, түүнчлэн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвлөл албан даалгавар буюу шийдвэр гаргах боломжтой байдлаар зохицуулсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийн хүрээнд хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай илүү тодорхой болгох шаардлагатай. Энэхүү судалгаанд шалгуур үзүүлэлтийн шаардлагад нийцээгүй, чиг үүрэг давхардсан гэснээс бусад зохицуулалт журмын төслийн зорилгыг хангасан гэж дүгнэлээ.

2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгаа хийсэн.

Журмын төсөл нь Нэг: Нийтлэг үндэслэл. Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоох, сонгох, чөлөөлөх. Гурав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах. Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах. Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт. Долоо: Бусад гэх 7 бүлэг, 46 хэсгээс бүрдсэн.

Журмаар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх болон тухайн журмаар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ тэдгээрийг биелүүлэх журмыг бүрэн тусгаагүй.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан үг үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих шаардлагыг бүрэн хангаагүй.

Тодруулбал, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн гишүүнийг сонгох тухай журмын төслийн 2.3, 2.4 дэх хэсгүүдэд хэн, хэнийг, ямар арга журмаар сонгох нь тодорхойгүй, зохицуулалтгүй орхигдсон. Өөрөөр хэлбэл, журамд зөвлөлийн гишүүн нь тухайн хурлын төлөөлөгч байх тухай болон зөвлөлийн гишүүнийг журамд заасны дагуу нэр дэвшүүлж тухайн иргэдийн хурлаас илээр эсхүл нууц санал хураалтаар олохын саналаар сонгох зохицуулалтыг тусгах шаардлагатай.

Мөн Журмын төслийн 2.7 дахь хэсэгт “Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх

шалтгаанаар удаа дараа хуралд оролцоогүй, хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар чөлөөлөх тухай саналыг хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ." гэж зохицуулсан байх боловч тус зохицуулалтад иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох тухай Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т заасан үндэслэлүүд бүрэн тусгагдаагүй.

Зөвлөлийн гишүүн нь иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч тул түүний бүрэн эрх дуусгавар болсноор зөвлөлийн гишүүнээр ажиллах боломжгүй болно. Иймд зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх үндэслэлд иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар үндэслэлийг иш татах эсхүл нэг бүрчлэн тусгах нь зүйтэй юм.

Мөн зөвлөл нь хурлын бэлтгэлийг хангах арга хэмжээ зохион байгуулах чиг үүргийн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлах /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны дэг зэрэг/ нийт төлөөлөгч наарт хамаарах дүрэм, журмын төслийг боловсруулж хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах тухай зохицуулалт нэмж, тусгах шаардлагатай. Энэ талаарх зохицуулалт журмаар зохицуулагдаагүй орхигджээ.

Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байх тул санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-н Хоёрдугаар бүлгийн 3.4.-т "Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын өгүүлбэрийн бүтэц нь энгийн буюу зэрэгцсэн нийлмэл хэлбэртэй байна. Хуулийн төслийн эх бичвэрийн өгүүлбэр нь нэг бүрэлдэхүүнтэй буюу нэрлэсэн, эсхүл эзэн биегүй байхаас зайлсхийх хэрэгтэй." гэж заасан.

Гэтэл журмын төслийн гурав, дөрөв, тав, долоо дугаар бүлгийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхойлоогүй. Журам нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам тул уг бүлгүүдэд заасан чиг үүргийг иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл хэрэгжүүлнэ гэж ойлгох боломжтой боловч хууль тогтоомжийг уншихад таамаглахгүйгээр ойлгогдох байдлаар тодорхой бичигдсэн байх шаардлагатай.

Иймд уг ажлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл гүйцэтгэх бол түүнийг тодорхой тусгах нь зүйтэй юм.

Жишээлбэл, Дөрөвдүгээр бүлэгт "Зөвлөл нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор дараах ажлыг хийнэ. Үүнд:" гэсэн хэсгийг зүйл болгон тусгах.

Үлгэрчилсэн загвар

Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулах.

4. Зөвлөл нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор дараах ажлыг хийнэ. Үүнд:

4.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу ээлжит хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.

4.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.4. дэх хэсэгт заасны дагуу ээлжит бус хуралдааны товыг Хурлын даргын захирамжаар баталж, бэлтгэл ажлыг зохион байгуулна.

4.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг ач холбогдоор нь эрэмбэлж хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хурлын даргын захирамжаар батална.

4.4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.2 дахь хэсэгт заасны дагуу иргэдийн гаргасан саналыг Хурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Мөн журмын төслийн 5.3-т "Хурлын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ" гэсэн зохицуулалт тусгасан байх боловч яг ямар /арга зүй, санхүү, хүний нөөц, техник туслалцаа зэрэг/ дэмжлэг үзүүлэх нь тодорхойгүй орхигддээ.

Дээрх үндэслэлүүдэд дурдсан журмын зүйл, заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Журмын төслийг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3. "Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу зардлын тооцоо хийх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-р хийсэн тайланд тодорхой тусгасан. Дүгнэлтийг уг тайлангаас харна уу.

4. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Журмын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн "харилцан уялдаа холбоотой байх" гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд 16 шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

№	Асуултууд	Хариулт
1	Журмын төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилтгоо нийцэж байгаа эсэх;	Тийм
2	Журмын төслийн "хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	"Төрийн хууль тогтоомж" гэснийг "Монгол Улсын хууль тогтоомж" эсхүл "Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж" болгож өөрчлөх.
3	Журмын төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм
4	Журмын төслийн зохицуулалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх;	Журмын төслийн санал, дүгнэлт, албан даалгавар гаргах, өргөдөл, гомдол хариу өгөхөөс бусад журмын

		төслийн зүйл, заалт хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай нийцэж байна.
5	Журмын төслийн зохицуулалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн зохицуулалттай давхардсан эсэх;	Үгүй
6	Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Үгүй
7	Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	
8	Журмын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Тийм
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Журмын төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх,	Үгүй
13	Хуулийн төслийн зохицуулалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх,	Тийм
14	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
15	Шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй

Журмын төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байх, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан эсэх, жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, авлига, хүнд суртал, шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байх, Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх, Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх, тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой шалгууруудыг хангасан гэж дүгнэлээ.

Харин журмын төслийн зарим зүйл, заалт "хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарч байх, журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгах, журмын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх шалгуурыг хангаагүй гэж дүгнэсэн.

- Журмын төслийн "хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх шалгуурыг бүрэн хангаагүй тухай:

Журмын төслийн 1.3-т "Зөвлөл нь үйл ажиллагаандaa төрийн хууль тогтоомжийг дээдлэхийн зэрэгцээ иргэдийн нийтлэг эрх ашиг, санал хүсэлтийг

харгалзан хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгоно." гэж зохицуулсан хэсгийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дахь хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 3.3.7-д нийцүүлж "төрийн хууль тогтоомж" гэснийг "Монгол Улсын хууль тогтоомж" эсхүл "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж" гэж өөрчлөх хэрэгтэй байна.

- Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаагүй, журмын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан тухай:

Журмын төслийн гурав дугаар бүлэг, дөрөв дүгээр бүлгийн 4.1-4.4, тав дугаар бүлгийн 5.1-5.5, зургаа дугаар бүлгийн 6.7, долдугаар бүлгийг хэрэгжүүлэх этгээдийг нэрлээгүй. Тиймээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-н Хоёрдугаар бүлгийн 3.4.-т заасан "...хуулийн төслийн эх бичвэрийн өгүүлбэр нь... эзэн биегүй байхаас зайлсхийх хэрэгтэй" гэсэн шаардлагыг хангаагүй.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг хүлээсэн.

Журмын төслийн үзэл баримтлалд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 онд батлагдсан шинэчилсэн найруулгад хуралдааны чөлөө цагт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байнгын, тасралтгүй ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын зөвлөл байгуулах тухай заасан гэжээ.

Дээрх хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах чиг үүргийг мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана." гэж заасан.

Журмын төслийн 3.3-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх чиглэл өгнө.", 3.4-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулна." гэсэн нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хорооны чиг үүрэгтэй давхацсан. Зөвлөл хяналт шалгалт, үнэлгээ хийж, ямарваа шийдвэр, албан даалгавар гаргах боломжгүй гэдгийг анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т "Хурал нь судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий бусад хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно." гэж тусгайлан заасан. Мөн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах чиг үүргийн хороотой байх тухай тус хуулийн 45 дугаар зүйлд тусгасан. Иймд журмын төслийн 4.5-т "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйл, 47.1-д заасан эрх бүхий этгээдээс өргөн барьсан асуудал, тухайн нэгжийн болон Хурлын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлыг Зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт өгч, уялдуулан зохицуулж, зөвлөн тусална." гэх зохицуулалт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны чиг үүрэгтэй давхацсан байна.

Мөн журмын төслийн 7.3 дахь хэсэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.9-д заасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын бүрэн эрхтэй давхардсан. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлд хуралд ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж, хариу өгөх бүрэн эрх хуулиар олгогдоогүй байхад хариу өгнө журамд тусгасан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмаар хэрэгжүүлэх иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулах, хурлын бэлтгэл хангах зарим зохицуулалт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тодорхойлсон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны чиг үүрэгтэй давхацсан.

Иймд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмын зохицуулалтад заасан ажлыг хэн хэрэгжүүлэхийг тодорхой тусгах, бусад этгээдтэй давхардсан чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх, ажлын онцлогийг нарийвчлан ялгаж зохицуулах нь зүйтэй байна.

4.3. Зөвлөмж

Журмын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-ын дагуу 4 шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэн хуулийн төсөл боловсруулагчид дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмаар хэрэгжүүлэх иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулах, хурлын бэлтгэл хангах зарим зохицуулалт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тодорхойлсон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны чиг үүрэгтэй давхацсан.

Иймд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмын зохицуулалтад заасан ажлыг хэн хэрэгжүүлэхийг тодорхой тусгах, бусад этгээдтэй давхардсан чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх, ажлын онцлогийг нарийвчлан ялгаж зохицуулах нь зүйтэй байна.

Мөн төсөлд орхигдуулсан зохицуулалтыг бүрэн тусгаж, үр нөлөөний тайлангийн ойлгомжтой байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийг шалгасан байдалд шаардлага хангаагүй гэж дүгнэгдсэн журмын зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ.

Үр нөлөөг үнэлэх судалгааг дүгнэхэд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмаар хэрэгжүүлэх иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулах, хурлын бэлтгэл хангах зарим зохицуулалт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тодорхойлсон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны чиг үүрэгтэй давхацсан.

Төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан гэж дүгнэлээ.

Харин судалгааны “Зөвлөмж” хэсэгт дурдсныг гүйцэтгэх шаардлагатай гэж дүгнэлээ.

---Оо---

ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 он.
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он.
4. Баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт. Монгол Улсын стандарт MNS5140-1 : 2021.
5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2019 он.
6. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УИХ-ын Тамгын газар, НҮБХХ-ийн захиалгаар хийсэн судалгаа, 2016 он.

“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцов.

Зардлыг тооцоход дараах зарчмыг баримталсан болно:

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах
-

Нэг. Хуулийн этгээдийн зардал

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээдэд заавал биелүүлэх шинжтэй үүрэг хариуцлага тусгаагүй тул нэмэгдэл зардал үүсэхгүй.

Хоёр. Төрийн байгууллагын зардал буюу орон нутгийн төсөвт үүсэх зардал

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгоход гарах зардлыг тооцоолно.

Чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг ажилтанд ногдох зардлаар үржүүлэн тооцох байдлаар дараах үе шаттай гаргадаг.

1. Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох
2. Ажил, үйлчилгээ гүйцэтгэх ажиллагааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох
3. Хүний нөөцтэй холбоотой гаргах зардлыг урьдчилан тооцох
4. Хувилбарыг нягтлах.
- 5.

Үе шат 1: Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т “Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлاغнах журмыг Засгийн газар батална.”, тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.”, 55.2-т “Энэ хуулийн 55.1-д заасан төсөв нь Хурлын үйл ажиллагааны болон ажлын албаны төсөөөс бүрдэнэ.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” гэж заасан бөгөөд журмын төслийн 2.8-д “Зөвлөлийн гишүүдэд

урамшуулал олгож болох ба урамшуулал олгох журмыг тухайн хурал батална." гэж тусгасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т "төсөөв" гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуриимтуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;; 4.1.27.-т "орон нутгийн төсөөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; 4.1.30-т "орон нутгийн төсвийн суурь зарлага" гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг¹ болон орон нутгийн чиг үүргийг² хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг³ хэлнэ гэж тус тус тодорхойлсон.

Дээрхээс дүгнэхэд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд хурал нь өөрийн төсөөвтэй байх, төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхижуулах арга хэмжээний зардлыг хурлын төсөөвт тусгана гэж Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан тул хурлын төсвөөс төлөөлөгчийг зөвлөлийн гишүүнээр ажиллахад үйл ажиллагаа нь дэмжих, чадавхжуулах үүднээс урамшуулал олгох боломжтой юм.

Үүний тулд Засгийн газраас батлах Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журамд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажилласны урамшуулал, зардлыг тусгасан байх шаардлагатай байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажилласан төлөөлөгчид урамшуулал олгохтой холбоотой зардлын тооцоход Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч нарт олгож буй урамшууллыг хэрхэн тооцож, төсөөвт тусгасныг сонгон судалж үзсэн.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдэд олгох урамшууллын хэмжээг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор тогтоож тус зардлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хурлын ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг товлосон хугацаанд багтааж хуралдаж, хэлэлцэх асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны төсөөвт оруулан өөрийн орон нутгийн төсөөвт тусгадаг байна.

¹ 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль 4.1.2."нэгжийн удирдлага" гэж нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тогтолцоо, үйл ажиллагааг;

4.1.3."нутгийн өөрийн удирдлага" гэж иргэд шууд, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг,

4.1.5."нутгийн өөрөө удирдах байгууллага" гэж аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурлыг,

² 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль 4.1.6."орон нутгийн чиг үүрэг" гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг;

³ Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл нь:

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны бэлтгэл хангах
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлт хангуулах арга хэмжээ зохион байгуулах,
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үндсэн чиг үүрэгтэй ажиллана.

Үе шат 2: Ажил, үйлчилгээ гүйцэтгэх ажиллагааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох

Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохын тулд дараах алхамыг гүйцэтгэнэ.



Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог /цаашид тохиолдлын тоо гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Тогтоо боломжтой тохиолдлын тоонд статистик мэдээллийн баримттай болон судалгаагаар тогтоож болох ажил үйлчилгээгээр хамаарна.

Тогтоо боломжгүй тохиолдлын тоонд үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил үйлчилгээ хамаарна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гэх мэт. Энэх нөхцөлд тохиолдлын тоонд үндэслэн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлохгүй, шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно.⁴

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэг тохиолдлын тоог тогтоох боломжгүй үйл ажиллагаа буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах, хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хяналт тавих, хуралдааны бэлтгэл хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцоонд оруулж тооцохгүй.

Төрийн байгууллага	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл		Ээлжит болон ээлжит бус хуралдааныг Хурлын даргын захирамжаар батлуулах
Бүрэлдэхүүн: 5-7 Иргэдийн	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бэлтгэл хангах	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг ач холбогдоор нь эрэмбэлж, хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хурлын даргын захирамжаар батлуулах
		Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд холбогдох материалыг

⁴ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. УБ, 281-282 дахь тал

төлөөлөгчд ийн хурлын төлөөлөгч		хянах, нэмэлт материал гаргуулах
	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийн хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлт хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл холбогдох Хурлын хороод, ажлын хэсэгт өгөх Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар Засаг дарга, дэргэдэх агентлагийн удирдлагын мэдээлэл сонсоно. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн талаар олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа мэдээллэх
	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг боловсруулах Дээрх журмыг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар журмыг хэлэлцүүлж, батлуулах Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо, ажлын хэсгийг ажлыг уялдуулах Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хорооны ажилд хяналт тавих

Үе шат 3: Хүний нөөцтэй холбоотой гаргах зардлыг урьдчилан тооцох

Зардлын тооцоог хүний нөөцийн⁵, материаллаг⁶, бусад⁷ гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлно. Өмнөх шатанд гаргасан ажиллах шаардлагатай хүний нөөцдэд зардлын бусад бүрдлээс оногдох хэсгийн нийлбэрээр зардлыг тооцдог.

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.-т “Анхдугаар хуралдаанаар тухайн шатны Хурлын даргыг оролцуулан аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийг 7-11, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийг 5-7, баг, хорооны Хурлын Тэргүүлэгчдийг 3-5 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.” гэж заасан байсан.

2020 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ...таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” гэсэн.

⁵ Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, тусlamж, төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн дунджаар гаргасан зардал хамаарна.

⁶ Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд ажлын байр, цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, ургсал зардал, хөрөнгө оруулалтын зардлууд орно.

⁷ Бусад зардал гэж тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг хэлнэ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журмын төслийн 2.1-т "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1. дэх хэсэгт заасан ёсоор аймаг, нийслэл, дүүрэгт 7, суманд 5, аймгийн төвийн болон хүн амын тоо нь 9 001 /есөн мянга нэг/-ээс дээш суманд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй тогтооно." гэж тус тус зохицуулжээ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн аймаг нийслэлд 7-11, сум дүүрэгт 5-7 байсан бол Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн бүрэлдэхүүн нь уг тооны доод хязгаараар буюу аймаг, нийслэл, хүн амын тоо 9 001-ээс дээш суманд 7, сум, дүүрэгт 5 байхаар тогтоосон байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийн асуудлаар бие даасан шийдвэр гаргахаас бусдаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн гүйцэтгэх шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хурлын хороо, ажлын хэсгийг уялдуулан зохицуулах чиг үүрэг нь одоо хүчин төгөлдөр хуулийн дагуу ажиллаж буй Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн бүрэлдэхүүний тоо доод хязгаараар тогтоогдсон тул Зөвлөл төсвийн хувьд одоо гарч буй зардлаас нэмэлт зардал үүсгэхгүй байх боломжтой байна.

Жишээлбэл, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хурлын ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг товлосон хугацаанд багтааж хуралдаж, хэлэлцэх асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны төсвийг 2018-2021 онд дараах байдлаар тогтоосон. Үүнд:

Он	Хэрэгжүүлэх хөтөлбөр: Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	Хүрэх үр дүн: НИТХ-н ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг товлосон хугацаанд багтааж хуралдаж, хэлэлцэх асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.	Зарцуулах төсөв /төгрөг/ 6,651.786.5 6,968.219.9 5,176.902.5 3,938.607.5 1,831.464.9
2021 ⁸			
2020 ⁹			
2019 ¹⁰			
2018 ¹¹			
2017 ¹²			

⁸ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 20/11 дугаартай "Нийслэлийн 2021 оны төсөв тухай" тогтоолын 6 дугаар хавсралт "Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн"-гийн 1.1 дэх зүйл.

https://ulaanbaatar.mn/Files2/2021.2020.0211_20201211021217.pdf

⁹ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн 9/36 дугаартай "Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 29/31 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 6 дугаар хавсралт "Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн"-гийн 1.1 дэх зүйл.

https://ulaanbaatar.mn/Files2/20209362019.12.16_20191220125554.pdf

¹⁰ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20/17 дугаартай "Нийслэлийн 2019 оны төсөв батлах тухай" тогтоолын 6 дугаар хавсралт "Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн"-гийн 1.1 дэх зүйл.

https://ulaanbaatar.mn/Files2/2019lusuv_20181210125907.pdf

¹¹ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/22 дугаартай "Нийслэлийн 2018 оны төсөв батлах тухай" тогтоолын 5 дугаар хавсралт "Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн"-гийн 1.1 дэх зүйл.

https://ulaanbaatar.mn/Files2/2018_20171211045412.pdf

¹² Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 6/11 дугаартай "Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай" тогтоолын 2 дугаар хавсралт "Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн"-гийн 1.1 дэх зүйл.

<https://ulaanbaatar.mn/Uploads/%D0%9D%D0%B8%D0%B9%D1%81%D0%BB%D1%8D%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%202017%20%D0%BE%D0%BD%D1%8B%D2%01%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%B2.pdf>

Дээрх батлагдсан төсвийн гүйцэтгэл хэтрэлд хэмнэлтийн шалтгааны тайландаа цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын хэмнэлт нь Тэргүүлэгчдэд олгох урамшуулалтай холбоотой байна. Жишээлбэл, 2017 онд батлагдсан төсвөөс 5,034,033 төгрөг хэмнэсэн бөгөөд энэхүү хэмнэлт нь Тэргүүлэгчдэд олгох урамшууллыг төсвөөс бүрэн гаргаагүйтэй холбоотой байжээ.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2017-2020 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлд хэмнэлтийн шалтгааны тайлан:

Он	Зарлагын ангилаал	Батлагдсан төсөв /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/	Хэмнэлт /төгрөг/
2020 ¹³		880,042,900	767,904,746.07	112,138,153.93 ¹⁴
2019 ¹⁵	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	668,145,500	666,119,150.49	2,026,349.51 ¹⁶
2018 ¹⁷		544,336,800	544,336,799.1	0.9
2017 ¹⁸		475,038,400	470,004,367	5,034,033 ¹⁹

Тэргүүлэгчдэд олгож буй урамшууллын хэмжээг нийслэл, дүүрэг, аймагт хэрхэн тогтоосныг жишээгээр авч үзвэл:

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 08, 93 дугаар тогтоолоор Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд олгох урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгохоор тогтоосон.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 62 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ажиллах журам”-ын 7.3-т “Тэргүүлэгчдийн ажлын үр дүнг харгалзан сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.” гэж тусгасан.²⁰

Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 40 дугаартай “Урамшууллыг зогсох тухай” тогтоолоор “Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд хуралд оролцсон байдлыг нь үндэслэж олгодог байсан 50,000 /Тавин мянга/-н төгрөгийн урамшууллыг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоосугай...” гэж шийдвэрлэсэн.²¹

Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд 2018 онд 40 000 төгрөгийг урамшуулал болгон хуралдаанд оролцсон тохиолдолд олгодог байсан.

Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай “Үйл ажиллагааны зардал, урамшуулал олгох журам батлах тухай” тогтоолын нэгдүгээр хавсралтаар

¹³ <https://shilendans.gov.mn/org/4283?form=4591933&year=2020&month=12&group=0&task=3784>

¹⁴ Хэмнэлтийн тайлбар: Тэргүүлэгчдийн урамшууллыг ирцийг харгалзан олгодог, Ажилчдын үр дүнгийн урамшууллыг дүгнэж олгосноос үүссэн хэмнэлт болно.

¹⁵ <https://shilendans.gov.mn/org/4283?form=3710687&year=2019&month=12&group=0&task=3784>

¹⁶ Хэмнэлтийн тайлбар: Тэргүүлэгчдийн цалинг гүйцэтгэлээр нь олгодог.

¹⁷ <https://shilendans.gov.mn/org/4283?form=2815807&year=2018&month=12&group=0&task=3784>

¹⁸ <https://shilendans.gov.mn/org/4283?form=2021042&year=2017&month=12&group=0&task=3784>

¹⁹ Хэмнэлтийн тайлбар: Тэргүүлэгчдийн урамшил бүрэн гаргаагүй.

²⁰ <https://www.chingelteicouncil.mn/public/storage/resolutions/August2020/vA8MEIqpS9UL8fjCKHee.pdf>

²¹ <http://sukhbaatar.ub.khural.mn/n/80726>

"Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгчдэд үйл ажиллагааны зардал, урамшуулал олгох журам"-г баталсан. Уг журмын 4.5 дугаар зүйлд Тэргүүлэгчдэд олгох урамшуулал, зардлыг тогтоосон. Тэргүүлэгчийн хуралдаанд оролцсон тоо, идэвхи санаачлага ажлын үр дүнг харгалзан тус бүр 15 000 төгрөгөөр тооцож олгох гэж тусгажээ.²²

Харин Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 87 дугаартай "Тэргүүлэгчдийн урамшууллын цагийн хөлсийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 1 дэх заалтаар "Аймгийн иргэдийн төлөөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцож, хуралдаанаар хэлэлцэх асуудалд санал, дүгнэлтээ өгөх, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангах Тэргүүлэгчдийн урамшууллын нэг цагийн хөлсийг 2019 оны 3 дугаар улирлаас эхлэн 1904 төгрөгөөр, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2500 төгрөгөөр шинэчлэн тогтоож олгосугай..." гэжээ.²³

	Урамшууллын хэмжээ /төгрөг/	Олгох давтамж	Хуралдах тоо	Жилд нийт /төгрөг/
Нийслэл	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ²⁴	Сар бүр	Сард 2-оос доошгүй удаа хуралдахаар журамласан. 2020 онд 24 удаа хуралдсан.	10 080 000
Чингэлтэй дүүрэг	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Сар бүр	Сард 2-оос доошгүй	10 080 000
Сүхбаатар дүүрэг	2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 50 000	Хуралдаанд оролцсон тоо	-	-
Хэнтий аймаг	15 000	Хуралдаанд оролцсон тоо	Долоо хоног бүрийн 5 дахь өдөр хуралдахаар журамласан. 2020 онд жилд 26 удаа хуралдсан.	390 000
Төв аймаг	2500	Нэг цагийн хөлс	-	-
Говьсүмбэр аймаг	2018 онд 40 000	Хуралдаанд оролцсон тоо	-	-

Дээр дурдсанчлан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд олгох урамшууллыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид өөрийн бүрэн эрхийн хүрээнд харилцан адилгүй тогтоож, олгож байна.

²² <http://khentii.khural.mn/n/115600>

²³ <http://tov.khural.mn/n/172886>

²⁴ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оы 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаартай "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол

Гэсэн хэдий ч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг дээрх жишээний дагуу аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сар бүр тооцож олгох боломжтой.

Дээрх жишгийн дагуу олгож байгаа иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй. Харин Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч нарт урамшуулал олгодоггүй хурлуудын төсөвт дээрх хэмжээний нэмэлт зардал үүсч болохоор байна.

Үе шат 4: Хувилбарыг нягтлах

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд урамшуулал олгож буй хурлын төсөвт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн бүрэлдэхүүн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон нэмэлт зардал гаражгүй. Харин хурлын тэргүүлэгч нарт урамшуулал олгодоггүй хурлын төсөвт нэмэлт зардал үүсэхээр байна.

Гурав. Иргэний зардлыг тооцох

Уг журмын төслийг хэрэгжүүлэхэд иргэдэд үүсэх, нэмэгдэх зардал үүсэхгүй гэж үзэв.

---Оо---

**“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар
эгүүлэн татах журам”-ын төслийн үр нөлөөний үнэлгээ**

АГУУЛГА

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

**ХОЁР. ЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН
БАЙДАЛ**

- 2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
- 2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
- 2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
- 2.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
- 2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

**ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ
ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ**

- 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

УДИРТГАЛ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Тус хуулийг хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоол батлагдсан.

Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 53 дугаар захирамжаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль, тогтоомжийг нийцүүлэх зорилго бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх..." гэж заасан.

Хуулийн дээрх зорилтын хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам"-ын төсөлд судалгаа, шинжилгээ хийлзэ.

Энэхүү үнэлгээний судалгааны зорилго нь 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт "Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна"; 42.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална" гэж заасны дагуу төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар эгүүлэн татах журмын төслийг боловсруулсан байна.

Уг журмын төслийн зарим зохицуулалт /хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, журмын зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжихэд хууль тогтоомж хоорондын зөрчилдөөн үүсэхгүй байдлаар боловсруулах, журмын төслийн чанарыг сайжруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Иймд үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хууль, "Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд¹ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлзэ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Журмын төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

- 1.3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГЖУРМЫИН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээг хийхдээ журмын төслийн зорилго, үйлчлэх хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан б шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Зардал;
3. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтуүдийг сонгож авахдаа дараах үндэслэлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан журмын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, журмын төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь журмын төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхдээ журмын төслийн үзэл баримтлалтай танилцаж, журмын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, журмын төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн боломж хүрээнд тухайн журмын төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, журмын төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно. Энэхүү үнэлгээний хүрээнд үнэлгээний хүрээнд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг журмын төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс журмын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, “Аргачлал батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хувьд: Журмын төслийн зохицуулалт нь иргэн, аж ахуй нэгж, байгууллага болон улсын төсөвт санхүүгийн ямар ачаалал, эсхүл хөнгөлөлт, хэмнэлт бий болгох, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар зардал үүсэх, зэргийг тооцоолохоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон. Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие

даасан тайлан болж гарахыг энд тэмдэглье.

“Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн журмын төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган тогтоолыг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хууль тогтоомжийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд чиглэсэн тул уг журмын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ХОЁР. ЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ бүлэгт уг журмын төслийн үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгоходоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үндэслэл, эгүүлэн татах процесстой холбоотой ач холбогдол бүхий заалтыг сонгож тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Журмын төслийн 1.1-д “Энэхүү журмын зорилт нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (цаашид Хурлын төлөөлөгч гэх)-ийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үндэслэл, нарийвчилсан журмыг тогтооход оршино” гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээг журмын төслөөр тавьсан зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д Монгол Улсын иргэн “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэж заасан байдаг.

Энэ хүрээнд Монгол Улсын өмнөх гурван Үндсэн хууль иргэдийн сонгох, сонгогдох эрхийг ямар нэг хэмжээнд баталгаажуулсан ч сонгууль нь хүмүүс хүсэл зоригоо шууд илэрхийлэх хууль ёсны хэрэгсэл байж чадаагүй билээ. 1992 оны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэж заасан. Энэхүү богино заалт маш өргөн утгыг агуулах бөгөөд үүнийг 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт дэлгэрүүлэн төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхийг иргэдэд эдлүүлэхийг хүлээн зөвшөөрсөн. Сонгуультай холбоотой

асуудлыг ихэвчлэн үндсэн хуулиар зохицуулсан байдаг.² Түүнчлэн сонгох эрхтэй холбоотой хамгийн чухал асуудлын нэг бол Үндсэн хуулиар баталгаажуулсан тэгш сонгох эрх юм. Үндсэн хуулийн 14.1-д хүн бүр “хуулийн өмнө эрх тэгш,” гэж заасан нь тэгш сонгох эрхийг өөртөө багтаадаг.³

Монгол Улс 1990, 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 онд парламентын сонгуулийг 9 удаа, 1993, 1997, 2001, 2005, 2009, 2013, 2017, 2021 онд ерөнхийлөгчийн сонгуулийг 8 удаа, 1990, 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 онд аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийг 9 удаа тус тус амжилттай зохион байгуулж, төрийн эрх мэдлийг сонгуулийн үр дүнгийн дагуу тайван замаар (2008.08.01-ийг эс тооцвол) шилжүүлэх соёл төлөвшсөн. Эдгээр сонгуулиудыг олон улсын байгууллагуудын болон гадаад улсын, мөн дотоодын иргэний нийгмийн төлөөлөгчид ажиглаж ерөнхийдөө ардчилсан сонгууль явуулсан гэж үнэлж ирсэн.⁴

2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн үзэл баримтлалд “Нутаг дэвсгэрийн чанартай асуудлыг шийдвэрлэх талаар Хурлын эрх хэмжээг тодорхой болгосны үндсэн дээр НӨҮБ-ын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, хуралдааны дэг, иргэдийн Төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг мөн чанарт нь дүйцүүлэн тодорхой зохицуулсан зүйл, заалтыг хуульд тусгах, *Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, эгүүлэн татах үндэслэл, журмыг нэвтрүүлэх замаар хариуцлагын тогтолцоог бий болгох*” гэж заасан байна.

Энэ хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татах”; 42.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална” гэж заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу журмын төслийг боловсруулах шаардлага бий болсон.

Хүснэгт 1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон, зүйл заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1.	1.1. Энэхүү журмын зорилт нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (цаашид Хурлын төлөөлөгч гэх)-ийг сонгогчдын саналаар эгүүлэн татах	Төслийн 1.1, 1.2 дахь хэсэг

² Д.Солонго. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны захиалгаар хийсэн судалгаанаас.

³ Б Чимид. Сонгуульд суралцахуй (*тогтолцоо, үйл явц, эрх зүй*) (УБ, 2008), 55.

⁴ О.Мөнхсайхан, Очирбал. Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал. тулгамдсан асуудал, шийдэл. Судалгааны тайлан. 2021 он.

<p>үндэслэл, нарийвчилсан журмыг тогтооход оршино.</p> <p>1.2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.</p>	
--	--

2.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн Үндсэн хуулиндаа тусгасан. Ардчилсан улс болохынхоо хувьд төлөөллийн ардчиллын зарчмаар сонгуулиар өөрийн төлөөний хүнээ сонгож төрийн үйл ажиллагааг эрхлүүлэхээр илгээдэг.

Тэгвэл тэрхүү өөрийг нь төлөөлсөн төлөөлөгч нь төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй гэж үзсэн тохиолдолд “тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны хоёр буюу түүнээс олон иргэн хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.”, “Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэд хамтын санал гарган санаачилна.” гэж заасан нь практикт хэрэгжих боломжийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дээрх хоёр асуудлын үр нөлөөг нь тооцооор сонгосон болно.

Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон, зүйл заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах	<p>Журмын төслийн 9.1 дэх хэсэгт тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны хоёр буюу түүнээс олон иргэн хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.</p> <p>Журмын төслийн 9.2-т “Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэд хамтын санал гарган санаачилна.”</p>

2.3. "Зардал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал

Төслийн улмаас хаана, хэнд ямар хэмжээний зардал үүсч байна гэдгийг нарийвчлан тооцох шаардлагатай бөгөөд энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт болох "Хууль

тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу судалж зардлыг тооцно.

2.4.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг журмын төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. Хууль ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн хуулийн төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалzan журмын төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийнэ. Журмын төсөл 9 бүлэг, 31 зүйлтэй./

2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлагдах журмын төслийн зүйл, заалт нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах шалгуураар журмын төслийг бүхэлд нь судлан үзнэ. Журмын төсөл 9 бүлэг, 31 зүйлтэй. Үүнд:

1. Журмын төслийн зохицуулалт нь тухайн журмын зорилттойгоо нийцэж байгаа эсэх;
2. Журмын төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;
3. Журмын төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн журмын төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;
4. Журмын төслийн зохицуулалт тухайн журмын төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх;
5. Журмын төслийн зохицуулалт тухайн журмын төслийн болон бусад хуулийн зохицуулалттай давхардсан эсэх;
6. Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;
7. Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;
8. Журмын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;
9. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;
10. Татварын хуулиас бусад журмын төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;
11. Тухайн журмын төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;
12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх,
13. Журмын төслийн зохицуулалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх,
14. Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх;
15. Шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

16. Журмын төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 3. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Журмын төслийн 1.1, 1.2 дахь хэсэг	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Журмын төслийн 9.1 дэх хэсэг.	Практикт төслийн энэ заалт хэрэгжих боломжтой эсэхийг судлах. Хэрхэн хэрэгжүүлэх.
3.	Ойлгомжтой байдал	Журмын төслийг бүхэлд нь тооцно	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Журмын төслийг бүхэлд нь тооцно	Журмын төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу журмын төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

Журмын төслийн 1.1-д Энэхүү журмын зорилт нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (цаашид Хурлын төлөөлөгч гэх)-ийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үндэслэл, нарийвчилсан журмыг тогтооход оршино.

Журмын төслийн 1.2-т Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.

Сонгуульт албан тушаалтны бүрэн эрхийг сонгогч/иргэдийн саналаар хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үйл явцыг “эгүүлэн татах” гэнэ. Өөрөөр хэлбэл, үүнийг сонгуульт албан тушаалтанд сонгогчдоос хүлээлгэх хариуцлагын нэг төрөл гэж ойлгож болох бөгөөд олон улсад ихэнхдээ “эгүүлэн татах” санал хураалт/санал асуулгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлдэг.⁵

Журмын төслийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эрхийн талаар:

“2.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эрх нь төлөөлөгчийн үүргээ биелүүлж байгаа эсэхэд нь сонгогчдоос хяналт тавих нэг хэрэгсэл мөн.

2.2.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эрх нь зөвхөн тухайн төлөөлөгчийг сонгосон тойргийн сонгогчдод хадгалагдана.

2.3.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах эрхийг зөвхөн холбогдох хуульд болон энэхүү журамд заасан үндэслэлээр хэрэгжүүлнэ.

2.4.Тухайн төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрснөөс хойш 12 сарын дотор, түүнчлэн сонгууль болох хүртэл 6 сарын дотор эгүүлэн татах эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно” гэж заасан.

Журмын төслийн 4.1-д хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж оролцох” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуульд иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргана хэмээн заасантай нийцэж байна.

Мөн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох нь сайн дурын үндсэн дээр хэрэгжинэ. Хэн ч түүнийг санал хураалтад оролцох буюу эс оролцохыг албадаж болохгүй бөгөөд саналаа өөрөө чөлөөтэй гаргах эрхтэй байхаар зохицуулсан нь иргэний төрийг удирдах хэрэгт оролцох, аливаа нууцад хамаарснаас бусад мэдээллийг олж авах эрхийг хязгаарлаагүй байна.

Түүнчлэн журмын төслийн 5.1-д “Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад, түүнчлэн эгүүлэн татахтай холбоотой хууль тогтоомжид нийцсэн аливаа үйл ажиллагаанд тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн оролцох эрхтэй” гэж сонгох эрхийн баталгааг хангасан байна.

Манай Улсын хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, тэдгээрийн төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа нийт (2020 оны сонгуулийн үр дүнгээр сонгогдсон 8169 төлөөлөгч байгаа) төлөөлөгчийг хамаарах бөгөөд МУЗЗНДНТУТХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна”; 42.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална” гэж заасан зорилгод нийцсэн байна.

3.2. Практикт хэрэгжих боломж

⁵ Тогтоолын төслийн үзэл баримтлалд.

Журмын төслийн 9.1 дэх хэсэгт тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны хоёр буюу түүнээс олон иргэн хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.

Журмын төслийн 9.2-т "Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэд хамтын санал гарган санаачилна."

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхтэй болохыг баталгаажуулсан байдаг. Аль нэгэн нам, байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд ялгаварлан гадуурхахыг хориглодог.

Эвлэлдэн нэгдэх эрх нь зарим тохиолдолд улс төр, соёл, зугаа цэнгэл, спорт, нийгэм, хүмүүнлэгийн тусламж зэрэг өргөн хүрээг хамрах нь бий. Судлаач Жереми Мак Брайд "жинхэнэ ардчилал" бий болгохын тулд нийгмийн бүхий л түвшинд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг здлэх, нөгөө талаас эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс тус эрх чөлөөг хүндэтгэх шаардлагатайг онцолсон. Үүний зэрэгцээ ямарваа нэгэн байдлаар нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө ялгаварлан гадуурхах, доромжлох, зүй бусаар харьцах явдлыг хориглодог нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг давхар хүндэтгэж байгаагийн илрэл юм.⁶

Журмын төслийн 9.1-д зааснаар тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны хоёр буюу түүнээс олон иргэн хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй. Мөн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэд хамтын санал гарган санаачлах эрхтэйгээр заасан байна.

Түүнчлэн, Орон нутгийн Хурлын сонгуулийн нэг тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа иргэд хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлаар саналаа тухайн Хуралд өргөн мэдүүлэх, тухайн саналаа бичгээр үйлдэж, холбогдох нотлох баримтын хамт тухайн хүргүүлэх, Хурал саналыг хүлээн аваад 14 хоногийн дотор шийдвэрлэх үүрэгтэй байдлаар заасан тухайн үйл ажиллагааг тодорхой практик хэрэгжүүлэх процесс тодорхой байна гэж үзэж байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан "сайн дураараа эвлэлдэн" нэгдэх эрхийн баталгааг хангасан байна гэж үзэж байна.

3.3. Ойлгомжтой байдал

⁶ Эвлэлдэн нэгдэх эрх <https://nhrctm.gov.mn/%D0%BE%D1%80%D0%BE%D0%BD-%D0%BD%D1%83%D1%82%D0%B0%D0%B3/%D3%A9%D0%BC%D0%BD%D3%A9%D0%B3%D0%BE%D0%B2%D1%8C%D1%8D%D0%B2%D0%BB%D1%8D%D0%BB%D0%B4%D1%8D%D0%BD-%D0%BD%D1%8D%D0%B3%D0%B4%D1%8D%D1%85-%D1%8D%D1%80%D1%85/>

Журмын төсөл нь (1) Нийтлэг зүйл, (2) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл, (3) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах, (4) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлах, (5) Санал хураалтын хороо, санал хураалтын хэсэг, хэсгийн хороо, (6) Оролцогч талуудын бүрэн эрх, (7) Санал хураалт зохион байгуулах, (8) Санал хураалтын дүн гаргах, нэгтгэх, мэдээлэх, дахин санал хураалт явуулах, (9) Санал хураалттай холбоотой маргааныг шийдвэрлэх, хүлээлгэх хариуцлага гэх 9 бүлэг, 31 зүйлээс бүрдэж байх бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан Шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх

Шалгах хуулийн заалт	Хариулт
Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн	Уг шаардлагыг хангасан.

эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.

30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангаагүй.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу зардлын тооцоо хийх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-р хийсэн тайланд тодорхой тусгасан. Тооцооллыг уг тайлангаас харна уу.

3.5. Харилцан уялдаа

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”-ын төслийн уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан “харилцан уялдаа холбоотой байх” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь:

1. Журмын төслийн зохицуулалт нь тухайн журмын төслийн зорилттой нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд:

Журмын төслийн 1.1-д “Энэхүү журмын зорилт нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (цаашид Хурлын төлөөлөгч гэх)-ийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үндэслэл, нарийвчилсан журмыг тогтооход оршино” гэсэн.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Төлөөлөгчийн үргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна”; 42.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална” гэж заасан.

Журмын төсөл нь:

- (1) Нийтлэг зүйл;
- (2) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл;
- (3) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах;
- (4) Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлах;
- (5) Санал хураалтын хороо, санал хураалтын хэсэг, хэсгийн хороо;
- (6) Оролцогч талуудын бүрэн эрх;
- (7) Санал хураалт зохион байгуулах;
- (8) Санал хураалтын дүн гаргах, нэгтгэх, мэдээлэх, дахин санал хураалт явуулах;

(9) Санал хураалттай холбоотой маргааныг шийдвэрлэх, хүлээлгэх хариуцлага гэх 9 бүлэг, 31 зүйлээс бүрдсэн бөгөөд журмын төслийн зохицуулалт зорилтод нийцэж байна.

2. Журмын төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх шалгуурын хүрээнд:

Журмын төслийн 4.1-д “Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж оролцоно”, 4.2-т “Монгол Улсын иргэн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтад оролцох нь сайн дурын үндсэн дээр хэрэгжинэ. Хэн ч түүнийг санал хураалтад оролцох буюу эс оролцохыг албадж болохгүй бөгөөд саналаа өөрөө чөлөөтэй гаргах эрхтэй”, 4.3-т “Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг аливаа сонгуулийн санал хураалттай нэгэн зэрэг явуулахыг хориглоно”, 4.4-т “Санал хураалтыг бэлтгэх, эрхлэн явуулах, санал тоолох болон санал хураалтын дүн гаргах үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байна”, 4.5-д “Санал хураалтын үр дүнд Хурлын төлөөлөгчийг эгүүлэх татах шийдвэр гараагүй бол тухайн төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг 12

сарын туршид дахин явуулахгүй", 4.6-д "Иргэд Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл болон эгүүлэн татах асуудалд хамаарах аливаа үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг олж авах эрхтэй байна" гэж тус тус заасан.

Хуулийн зарчим нь түүний зорилго, агуулгыг хэрэгжүүлэхэд нэлэөлдөг хөшүүрэг тул хуулийн зүйл, заалтыг хэрэглэхэд эргэлзээ гарсан тохиолдолд асуудлыг тухайн хуулийн зарчмын хүрээнд авч үздэг. Иймд хуулийн зарчмын утгыг бүрхэгдүүлсэн цөөн үгээр, эсхүл хэд хэдэн зарчимд хамаарах утгыг нэг зарчим болгох, хэтэрхий нуршсан олон үгээр томьёолохоос зайлсхийнэ гэж Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дахь хавсралт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 3.3.7-д заасан.

Тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д "нутгийн өөрийн удирдлага нь тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлж, иргэдийн саналыг харгалзан үздэг байх"; 12.1.7-д "ил тод байх, иргэдийг мэдээллээр хангах" гэх зарчмыг тусгасан.

Гэтэл журмын төслийн зарчим нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан иргэний эдлэх эрхийг заасан бөгөөд зарчим гэж үзэхэд учир дутагдалтай байна. Иймд "Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан зарчмыг удирдлага болгоно" гэж зохицуулж болох юм.

3.Журмын төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн журмын төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар нэр томьёо нь олон утгатай эсхүл өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай, мөн шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол нэр томьёоны тайлбар хэрэглэхээр заасан.

Журмын төслийн 3.1.1-д "Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах" – тойргийн сонгогчдоос Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа гэж үзээд энэ журамд заасны дагуу тухайн тойрот явуулсан санал хураалтын дүнгээр Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох" гэж заасан.

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд "Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах" асуудлын талаар огт тусгагдаагүй байсан бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн үзэл баримтлалд "...Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, эгүүлэн татах үндэслэл, журмыг нэвтрүүлэх замаар хариуцлагын тогтолцоог бий болгох" гэж заасан байдаг. Энэ хүрээнд тус хуулийн 42 дугаар зүйлд "Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах" зохицуулалтыг оруулсан нь шинэ тутам харилцааг бий болгож, нэр томьёоны тайлбар хийсэн нь оновчтой болсон гэж үнэллээ.

Журмын төслийн 3.1.2-т "Эгүүлэн татах үндэслэл" – энэ журамд заасан Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг үүсгэх нөхцөл" гэж заасан.

Харин журмын төслийн хоёрдугаар бүлэг "Хурлын төлөөлөгчийн эгүүлэн татах үндэслэл" гэж заасан бөгөөд журмын төслийн 7.1-д "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт зааснаар "төлөөлөгчийн үргээ биелүүлэхгүй байгаа" нь Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл болно" гэжээ.

Тэгвэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Төлөөлөгчийн үргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна" гэж заасан бөгөөд уг хуулийн зохицуулалтад зааснаар бол "Төлөөлөгчийн үргээ биелүүлэхгүй байгаа" гэдгийг оновчтой, тодорхой заагаагүй харагдаж байна. Иймд журмын төслийн 3.1.2, 7.1-д заасан нь ойлгомжгүй, тодорхой биш байгаа нь журмын төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэхгүй байна.

Түүнчлэн журмын төслийн 7.2-т "Хуульд зааснаас өөр үндэслэлээр Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачилж болохгүй" гэж заасан ба Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т "Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална" гэж заасан бөгөөд Улсын Их Хурлаас батлах журмаар нарийвчлан зохицуулж өгөх хуулийн зохицуулалтыг журмын төслийн 7.2-т зааснаар хязгаарласан гэж үзэж болохоор байна.

Мөн журмын төслийн 8.1-т "Хурлын төлөөлөгчийн үргээ биелүүлэхгүй байх гэдэгт тухайн тойргийн сонгогчдоос Хурлын төлөөлөгчийг өөрсдийнх нь эрх ашгийг төлөөлөх үргээ хэрэгжүүлээгүй, Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй гэж үзэхийг ойлгоно" гэж үүргээ биелүүлээгүй гэдгийг тодорхойлохоор зохицуулсан байна. Гэвч иргэний "эрх ашгийг төлөөлөх үргээ хэрэгжүүлээгүй" гэдэгт ямар шалгуур байх талаар дэлгэрэнгүй оновчтой зохицуулаагүй байна.

Журмын төслийн 3.1.3-т "Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах" – Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах талаар тухайн төлөөлөгчийн сонгогдсон тойргийн сонгогчдоос санаачлах" гэж нэр томьёоны тайлбар хийсэн нь оновчтой болсон гэж үнэллээ.

4. Журмын төслийн зүйл, заалт тухайн журмын төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх шалгуурын хүрээнд нийцсэн байна.

5. Журмын төслийн зүйл, заалт тухайн журмын төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй байна.

6. Журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгах шалгуурын хүрээнд:

Журмын төслийн 10.1-д "Орон нутгийн Хурлын сонгуулийн нэг тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа иргэд хамтаараа Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлаар саналаа тухайн Хуралд өргөн мэдүүлнэ. Саналаа бичгээр үйлдэж, холбогдох нотлох баримтын хамт тухайн Хуралд хүргүүлнэ" гэж заасан бөгөөд журмын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тусгах шаардлагыг хангасан байна.

Харин журмын төслийн 16-д Санал хураалтын хороо, хэсгийн хорооны бүрэн эрхийн талаар тусгасан бөгөөд санал хураалтын хороо болон хэсгийн хорооны бүрэлдэхүүнд ямар этгээд орох, хэрхэн ажиллах талаар дурдаагүй байна.

7. Журмын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх шалгуурын хүрээнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Тайлбар
<p>15. Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтын хэсэг</p> <p>15.1.Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтын хэсгийг тухайн төлөөлөгчийн сонгогдсон тойргийн нутаг дэвсгэрт байгуулна. Санал хураалтын хэсгийг байгуулахдаа тухайн Хурлыг сонгох сонгуулийн хэсгийг байгуулсан зарчмыг баримтална.</p>	<p>Хуульд энэ тухай зохицуулалт тусгагдаагүй.</p>	<p>Журмын төслийн 15-д Тухайн Хурлыг сонгох сонгуулийн хэсгийг байгуулсан зарчмыг баримтлана гэж тодорхойгүй орхигдуулсан байна. Тухайлбал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Сонгуулийн хэсэг байгуулахдаа улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэнэ” гэж зохицуулсан.</p> <p>Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн 13 дугаар</p>

		зүйлд заасны дагуу санал хураалтын хэсгийг байгуулна гэж тодорхой зааж өгөх шаардлагатай.
--	--	---

8.Журмын төсөлд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлаарх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх шалгуурын хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчилсэн найруулгыг судлан үзэхэд давхардуулсан зохицуулалт байхгүй байна.

9.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт хамааруулаагүй байна.

10.Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх шалгуурын хүрээнд хуулийн төслийг судлан үзэхэд шинээр тусгай зөвшөөрөл олгох талаар зохицуулалт агуулаагүй байна.

11.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан эсэх, жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, авлига, хүнд суртал, шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд судлан үзэхэд шалгуурыг хангасан байна.

12.Журмын төслийн зохицуулалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан байна.

13.Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй байна.

14.Шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.

15.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийг судлан үзлээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой дагалдан гарах бусад хуульд Зөрчлийн тухай хууль багтаагүй. Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлагдах “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”-д зөрчилд холбогдох зохицуулалт агуулаагүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ДҮГНЭЛТ

Журмын төслийн үр нэлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нэлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд. Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтаар батлагдах “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар

эгүүлэн татах журам" нь тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, байдлаар боловсруулагдсан байна гэж дүгнэлээ.

Журмын төсөлд дараах өөрчлөлт оруулахыг зөвлөж байна:

1/Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8-д "Тогтоолын төслийн заалтыг дараах байдлаар дугаарлана: 36.8.1-д заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. гм/; 36.8.2-т заалтын доторх дэд заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор /1/ гм/ заасан. Уг журмын төслийн дугаарлалт нь хууль тогтоожийн шаардлагад нийцээгүй байгааг анхаарч зөв дугаарлах.

2/Журмын төслийн зарчим нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан иргэний эдлэх эрхийг заасан бөгөөд зарчим гэж үзэхэд учир дутагдалтай байна. Иймд "Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан зарчмыг удирдлага болгоно" гэж өөрчлөн найруулах.

3/Журмын төслийн нэр томьёоны тодорхойлолтыг ойлгомжтой болгох. Тухайлбал, журмын төслийн 3.1.2-т "Эгүүлэн татах үндэслэл" – энэ журамд заасан Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг үүсгэх нөхцөл" гэснийг дэлгэрүүлэх, журмын төслийн заалтуудтай уялдуулах.

4/Журмын төслийн 7.2-т "Хуульд зааснаас өөр үндэслэлээр Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачилж болохгүй" гэж, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т "Энэ хуулийн 42.1-д заасны дагуу эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална" гэж заасан бөгөөд Улсын Их Хурлаас батлах журмаар уг харилцааг нарийвчилж, дэлгэрүүлэн зохицуулах байтал журмын төслийн 7.2-т зааснаар хязгаарласан байж болзошгүй байна.

5/Журмын төслийн 8.1-т "Хурлын төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байх гэдэгт тухайн тойргийн сонгогчдоос Хурлын төлөөлөгчийг өөрсдийнх нь эрх ашгийг төлөөлөх үүргээ хэрэгжүүлээгүй, Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй гэж үзэхийг ойлгоно" гэж үүргээ биелүүлээгүй гэдгийг тодорхойлохоор зохицуулсан байна. Гэвч иргэний "эрх ашгийг төлөөлөх үүргээ хэрэгжүүлээгүй" гэдэгт ямар шалгуур байх талаар дэлгэрэнгүй оновчтой зохицуулж өгөх.

6/Журмын төслийн 15-д "...Тухайн Хурлыг сонгох сонгуулийн хэсгийг байгуулсан зарчмыг баримтлана" гэж тодорхойгүй зохицуулалт оруулсан байна. Тэгвэл сонгуулийн хэсгийг байгуулах харилцааг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Сонгуулийн хэсэг байгуулахдаа улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэн" гэж зохицуулсан тул уг хуулийг эшлэх.

7/Журмын төслийн 16-д Санал хураалтын хороо, хэсгийн хорооны бүрэн эрхийн талаар тусгасан бөгөөд санал хураалтын хороо болон хэсгийн хорооны

бүрэлдэхүүнд ямар этгээд орох, хэрхэн ажиллах талаар дурдаагүй байна. Иймд журмыг хэрэгжүүлэх этгээдийн талаар тусгах.

---ooOoo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 он.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он.
- Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он.
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоол.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2019 он.
- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УИХ-ын Тамгын газар, НҮБХХ-ийн захиалгаар хийсэн судалгаа, 2016 он.
- Д.Солонго. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны захиалгаар хийсэн судалгаа.
- Б.Чимид, Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй), УБ, 2008 он
- Эвлэлдэн нэгдэх эрх Хүний эрхийн Үндэсний комиссын судалгаа. 2021 он.
- О.Мөнхсайхан, Очирбал. Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл. Судалгааны тайлан. 2021 он

**Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар
эгүүлэн татах журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо**

АГУУЛГА

УДИРТГАЛ	1
НЭГ. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛҮҮЛЭХ, ХҮРГҮҮЛЭХ ЗАРДАЛ	3
1.1. Саналын хуудсыг хэвлүүлэх зардал	3
1.2. Саналын хуудсыг аймаг, сум, санал авах байранд хүргэх тээвэрлэлтийн зардал:	3
1.3. Саналын хуудас хэвлүүлэх, хүргэх үеийн хамгаалалтын зардал:	3
ХОЁР. ЛАЦ, САНАЛЫН ХУУДАС БИТҮҮМЖЛЭН ХАДГАЛАХ УУТ БЭЛТГЭХ ЗАРДАЛ	4
2.1. Сонгуулийн хайрцагны нэг удаагийн лац авах зардал.....	4
2.2. Саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал.....	4
ГУРАВ. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛАХ СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЗАРДАЛ	5
3.1. Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгслийг ажиллуулах цахилгаан үүсгүүр түрээслэх, шатахууны зардал	5
3.2. Санал авах, тоолох, дүн гаргах техник хэрэгсэл иж бүрдлийг аймаг, нийслэлийн мэдээллийн технологийн баг, санал авах байрны даамалд хүлээлгэн өгөх, буцаан авах зардал	5
3.3. Санал авах байрны даамал тоног төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэж өгөх зардал	5
3.4. Аймгийн мэдээллийн технологийн баг санал тоолох, дүн гаргах иж бүрдэл техник хэрэгслийг хүлээж авах, буцаан хүлээлгэн өгөх томилолтын зардал ..	6
ДӨРӨВ. САНАЛЫН ХАЙРЦАГ ХИЙХ, ХҮРГЭХ, САНАЛ АВАХ БАЙРНЫ БОЛОН САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ, ТОХИЖУУЛАХ ЗАРДАЛ	6
ДҮГНЭЛТ	6
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	7

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно." гэж заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам /цаашид "журмын төсөл" гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу тооцлоо.

Журмын төсөлд тусгаснаар "санаачлагчаас хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалт явуулахыг дэмжиж буй иргэдийн гарын үсгийг цуглуулах, мөн санал хураалтыг товлосон өдрөөс хойш санаачлагч болон хурлын төлөөлөгч нь сонгогчдод ухуулга, сурталчилгаа, тайлбар хийхтэй холбоотой зардал"-ыг санаачлагч, хурлын төлөөлөгч өөрөө хариуцахаар байна.

Харин Журмын төслийн 19.1-д "Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлах, санал хураалтыг зохион байгуулахтай холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" гэж заажээ. Иймд энэхүү ажиллагаатай холбоотой орон нутгийн төсвөөс хэдий хэмжээний зардал гарахыг тооцох шаардлагатай байна. Зардлыг тооцоход тухайн сонгуулийн тойргийн сонгогчдын тоог зайлшгүй харгалзан үзэх ёстой. 2020 онд явагдсан орон нутгийн Хурлын сонгуулийн тойргуудын сонгогчдын тоог шинжлэн үзэхэд сумын ИТХ-ын нэг тойротг хамаарах сонгогчдын тоо 60-4500, аймгийн ИТХ-ын нэг тойротг хамаарах сонгогчдын тоо 420-4500, дүүргийн ИТХ-ын нэг тойротг хамаарах сонгогчдын тоо 470-24300, нийслэлийн ИТХ-ын нэг тойротг хамаарах сонгогчдын тоо 2430-54250 байна.¹ Иймд энэхүү тоонд үндэслэн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын нэг төлөөлөгчийг эгүүлэн татахад оролцох боломжтой сонгогчийн тоог доорх байдлаар гаргаж зардлын тооцоог хийсэн болно.

	Сонгуулийн нэг тойрог дахь сонгогчийн тоо
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 төлөөлөгч	2 500
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 төлөөлөгч	400
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 төлөөлөгч	45 000
Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 төлөөлөгч	10 000

Учир нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эсэх асуудал нь улс орон даяар бүх нийтийг хамарсан байдлаар явагдахгүй зөвхөн тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн сонгогдсон сонгуулийн тойргийн нийт сонгогчдын хүрээнд явагдах тул зардлын тооцоог гаргахдаа аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвхөн нэг төлөөлөгчийг эгүүлэн

¹ Журмын төслийн танилцуулга

татахад хэдий хэмжээний зардал гарахаар байгааг тооцож үзсэн. Унаа, томилолт, тээвэрлэлтийн зардал зэргийг тооцоход тодорхой нэг нэгжийг жишиг болгож авах шаардлагатай байсан тул аймгуудаас Архангай аймаг, сумдаас Арханхангай аймгийн Өгийнуур сум, мөн дүүргүүдээс Нийслэлийн Хан-Уул дүүргийг сонгож авсан болно.

НЭГ. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛҮҮЛЭХ, ХҮРГҮҮЛЭХ ЗАРДАЛ

1.1. Саналын хуудсыг хэвлүүлэх зардал

Саналын хуудсыг нэг бүрийг нь 1 500 төгрөгөөр (НӨАТ багтсан дүн) хэвлэнэ гэж үзвэл:

	Сонгогчийн тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	2 500	1 500₮	3 750 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	400	1 500₮	600 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	45 000	1 500₮	67 500 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	10 000	1 500₮	15 000 000₮

1.2. Саналын хуудсыг аймаг, сум, санал авах байранд хүргэх тээвэрлэлтийн зардал:

Энэ хэсэгт нислэгтэй аймаг (Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд) болон авто машинаар саналын хуудсыг хүргүүлэх боломжтой аймгийн тухайд зардал өөр өөр гарна. Жишээ болгож Архангай аймгийг авч үзэхэд: Цэцэрлэг хот ба Улаанбаатар хотын хооронд 460 км-ын зайдай ба Цэцэрлэг хотод саналын хуудсыг хүргүүлэхэд дараах унаа, томилолтын зардал гарахаар байна.

$$(460 \text{км} * 500 \text{төг} * 2 \text{ тал}) + (2 \text{ хүн} * 1 \text{ хоног} * 36,500 \text{төг}) = 460,000 \text{төг} + 73,000 \text{төг} \\ = 533,000 \text{ төгрөг}$$

Улаанбаатраас Өгийнуур сумын сонгуулийн хороо, сумын сонгуулийн хорооноос санал авах байранд хүргэх унаа, томилолтын зардал:

$$(360 \text{км} * 500 \text{ төг}) + (2 \text{ хүн} * 1 \text{ хоног} * 14,500 \text{ төг}) = 209,000 \text{ төгрөг}$$

1.3. Саналын хуудас хэвлүүлэх, хүргэх үеийн хамгаалалтын зардал:

Саналын хуудсыг хэвлүүлэх, тухайн сонгуулийн хороонд хүргэх үеийн хамгаалалтын зардал:

	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	100 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	100 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	100 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	100 000₮

БҮЛГИЙН ДҮН:

	Зардлын дүн
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	4 383 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	909 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	67 600 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	15 100 000₮

ХОЁР. ЛАЦ, САНАЛЫН ХУУДАС БИТҮҮМЖЛЭН ХАДГАЛАХ УУТ БЭЛТГЭХ ЗАРДАЛ

2.1. Сонгуулийн хайрцагны нэг удаагийн лац авах зардал

а/ Зөөврийн саналын 1ш хайрцагт 5ш лац хэрэглэнэ гэж тооцвол:

	Хайрцаг ²	Лацны үнэ	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	5ш	5*600₮	15 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	1ш	5*600₮	3 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	15ш	5*600₮	45 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	4ш	5*600₮	12 000₮

2.2. Саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал

Нэг утанд 300ш саналын хуудас хадгална гэж тооцвол:

	Саналын хуудсын тоо	Шаардлагатай уутны тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	2 500	9ш	5 500₮	49 500₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	400	2ш	5 500₮	11 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	45 000	150ш	5 500₮	825 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	10 000	34ш	5 500₮	187 000₮

БҮЛГИЙН ДҮН:

	Зардлын дүн
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	64 500₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	14 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	870 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	199 000₮

² Сонгуулийн тойротг байх боломжтой сонгуулийн хэсгийн тоог үндэслэж хайрцагны тоог гаргав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль: 13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвийн сум болон дүүрэгт 3000-аас илүүгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

ГУРАВ. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛАХ СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЗАРДАЛ

3.1. Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгслийг ажиллуулах цахилгаан үүсгүүр түрээслэх, шатахууны зардал

Энэ зардлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татахад гарах зардал гэж тооцов.

	Зардал	Нийт
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	5 хэсэг * /40 000₮ + 30 000₮/	350 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	1 хэсэг * /40 000₮ + 30 000₮/	120 000₮

3.2. Санал авах, тоолох, дүн гаргах техник хэрэгсэл иж бүрдлийг аймаг, нийслэлийн мэдээллийн технологийн баг, санал авах байрны даамалд хүлээлгэн өгөх, буцаан авах зардал

1/ Тоног төхөөрөмжийг авто машинаар ирж авах, хүлээлгэн өгөх, хүлээн авах аймгийн сонгуулийн хорооны ачааны зардал: Жишээ болгосон Архангай аймгийн тухайд: (460км * 2 тал * 1автомашин * 500₮) * 2 удаа = 920 000₮

2/ Тоног төхөөрөмжийг авто машинаар ирж авах, хүлээлгэн өгөх, хүлээн авах сумын сонгуулийн хорооны ачааны зардал: Жишээ болгосон Архангай аймгийн Өгийнуур сумын тухайд: (360км * 2 тал * 1автомашин * 500₮) * 2 удаа = 720 000₮

3/ Нийслэлийн сонгуулийн хорооны Мэдээллийн технологийн баг санал авах, тоолох, дүн гаргах 30ш ICP машиныг батерейн хамт хүлээн авах, хүлээлгэн өгөх ачааны зардал: Жишээ болгосон Хан-Уул дүүргийн тухайд: (10км * 2 тал * 3 автомашин * 500₮) * 2 удаа = 60 000₮

4/ Дүүргийн сонгуулийн хорооны Мэдээллийн технологийн баг санал авах, тоолох, дүн гаргах 8ш ICP машиныг батерейн хамт хүлээн авах, хүлээлгэн өгөх ачааны зардал: Жишээ болгосон Хан-Уул дүүргийн тухайд: (10км * 2 тал * 2 автомашин * 500₮) * 2 удаа = 20 000₮

	ICP машин	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	5ш	920 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	1ш	720 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	30ш	60 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	8ш	20 000₮

3.3. Санал авах байрны даамал тоног төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэж өгөх зардал

	Даамлын тоо	Зардал	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	3	1автомашин * 460км * 500₮ * 2 удаа	1 380 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	3	1автомашин * 360км *	1 080

		500₮ * 2 удаа	000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	4	10 000₮ * 2 удаа	80 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	4	10 000₮ * 2 удаа	80 000₮

3.4. Аймгийн мэдээллийн технологийн баг санал тоолох, дүн гаргах иж бүрдэл техник хэрэгслийг хүлээж авах, буцаан хүлээлгэн өгөх томилолтын зардал

Томилолтын зардал: Мэдээллийн технологийн баг тус бүрээс 2 хүн ирнэ гэж тооцвол: 1 аймаг (сум) * 2 хүн * 36,500 *2 хоног * 2 удаа = 292 000₮

	Мэдээлэл, технологийн баг	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	2	292 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	2	292 000₮

БҮЛГИЙН ДҮН:

	Зардлын дүн
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	2 942 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	2 212 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	140 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	100 000₮

ДӨРӨВ. САНАЛЫН ХАЙРЦАГ ХИЙХ, ХҮРГЭХ, САНАЛ АВАХ БАЙРНЫ БОЛОН САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ, ТОХИЖУУЛАХ ЗАРДАЛ

4.1. Санал авах байрыг бэлтгэх, тохижуулах, хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод зориулсан гарц бэлтгэх зардал санал авах байр бүрт 220 000₮ гэж тооцвол:

	Санал авах байр	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	5	1 100 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	1	220 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	15	3 300 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	8	1 760 000₮

ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн, 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журмын үйлчлэх хүрээнд

хамаарах төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргалаа.

Аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус журмын төслөөр иргэн, хуулийн этгээдэд үүрэг бий болгож шинээр зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй байна.

Харин Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэг төлөөлөгчийг эгүүлэн татах ажиллагаанд дараах зардал гарахаар байна гэж тооцов:

	Нийт үнэ
Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч	8 839 000₮
Сумын ИТХ-ын 1 төлөөлөгч	3 475 000₮
Нийслэлийн ИТХ-ын 1 төлөөлөгч	71 910 000₮
Дүүргийн ИТХ-ын 1 төлөөлөгч	16 575 000₮

Дээрх зардал нь журмыг хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал тул хялбаршуулах, үүргийг нэгтгэн бууруулах боломжгүй хэмээн дүгнэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Эрх зүйн баримт бичиг

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журмын төслийн үзэл баримтлал;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журмын төслийн танилцуулга;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2020 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал.

Хоёр. Гарын авлага, судалгааны тайлан

- Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал. 2013 он. ХЗДХЯ, ГОУХАН;
- Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага. 2016 он. ХЗДХЯ 2016 он;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, 2020 он.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам”-ын үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан

АГУУЛГА

УДИРТГАЛ	2
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР.ЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ.....	3
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	4
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	4
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	5
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	6
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	8
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	11
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	18
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	19
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	22
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	23
ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	27
4.1. Үнэлэлт, дүгнэлт	27
4.2. Зөвлөмж.....	29
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	31

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.22 дахь хэсэгт "Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бурдүүлнэ", мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ" гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн "Хууль тогтоомжийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам"-ын төсөлд "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлгээ хийхэд оршино.

Түүнчлэн энэхүү судалгаагаар "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам"-ын төслийн үр нөлөөг үнэлж давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам" буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлын зохицуулалтыг Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн сайжруулах боломжийг тодорхойлох, мөн журмыг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагч дэмжлэг үзүүлэх, улмаар журмын төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

"Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам"-ын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал" /цаашид "Аргачлал" гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Журмын төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

4. Ойлгомжтой байдал
 5. Зардал¹
 6. Харилцан уялдаа
- Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалzan үзсэн.

Тухайлбал,

1. Журмын төсөл нь Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэх, мөн журмын төслийн "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн (аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо) өөрчлөлтийг санаачлах, төлөвлөх, зохион байгуулах, оролцогч талуудын саналыг авах, тусгахад чиглэнэ." гэх зорилго нь уг зорилгод нийцсэн эсэх, журмын зохицуулалт нь журмын тус зорилгод нийцсэн эсэх;
2. Журмын төсөлд тусгагдсан асуудлууд болох 1/нэгжийг тодорхойлох үзүүлэлт (шалгуур), 2/Нэгжийг өөрчлөх асуудалд талуудын үүрэг, оролцоо, 3/Ажлын хэсгийн үүрэг, үйл ажиллагаа, 4/Иргэдийн санал авах, дүнг нэгтгэж мэдээлэх, 5/Хариуцлага, 6/Хавсралт зэрэг зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Журмын төсөлд тусгагдсан зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектуудын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсэн эсэх;
4. Журмын төслийн иргэдийн саналыг үндэслэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж өөрчлөх асуудал нь бүхэлдээ шинэ зохицуулалт учраас энэ нь хүлээн зөвшөөрөгдхөх эсэх;
5. Журмын төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгах;

ХОЁРЖУРМЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг журмын төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмжк орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй заалтын үр нөлөөг судална.

Түүнчлэн журмын төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалzan үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрийг тус бүрт нь авч үзье.

¹ Журмын төслийн "Зардал" гэсэн шалгуур үзүүлэлтийг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам"-ийн төслийн зардлын тооцоо гэсэн тусдаа судалгаагаар гүйцэтгэсэн тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл, түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтуудыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжий төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг. Энэ хүрээнд дараах асуудлуудыг зорилгодоо нийцсэн эсэхийг авч үзнэ.

-Журмын төсөл нь бүхэлдээ Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэх

-Журмын төслийн зорилго нь Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэх

Иймд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам”-ын төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Журмын төсөл нь бүхэлдээ Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэх	Журмын төсөл бүхэлдээ
2.	Журмын төслийн зорилго нь Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэх	Журмын төслийн 1.1 “Энэ журмын зорилго нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн (аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо) өөрчлөлтийг санаачлах, төлөвлөх, зохион байгуулах, оролцогч талуудын саналыг авах, тусгахад чиглэнэ.”

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд иргэдэд өөрчлөлтийн төслийг мэдэгдэх,

санал авах, түүнийг хүргүүлэхтэй холбогдсон үе шаттай холбоотой зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1.	Иргэдэд өөрчлөлтийн төслийг мэдэгдэхтэй холбоотой заалтууд	-Журмын төслийн 6.3.1 дэх хэсэг "...иргэдэд З сарын дотор хэвлэмэл танилцуулга, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэн" гэх -Журмын төслийн 6.3.2 дэх хэсэг "...иргэдэд 45 хонгийн дотор цахим, хэвлэмэл, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ." гэх
2.	Журмын иргэдээс санал авах үйл ажиллагааны үе шаттай холбоотой заалтууд	-Журмын төслийн 6.5 дахь хэсэг "Ажлын хэсэг нь нэгжийн өөрчлөлтийн төсөлтэй холбоотой баг, хороо, сум, дүүргийн иргэдийн санаа бодлыг баг, хорооны ИНХ, сум, дүүргийн ИТХ-аар шатлан хэлэлцэж, дэмжсэн болон эс дэмжсэн учир шалтгааныг тэмдэглэж, албажуулна." гэх
3.	Иргэдээс санал авахтай холбоотой заалтууд	-Журмын төслийн 8.1 дэх хэсэг "Нэгжийг өөрчлөх асуудлын талаар орон нутгийн иргэдээс өөрчлөлтийг "дэмжиж байна", "дэмжихгүй" гэсэн хоёр санал авна." гэх

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэр томьёоны тайлбарт ойлгомжгүй байдал бий болгосон, бичиглэл нь хууль тогтоомжийн тухай хуульд нийцээгүй, тохиромжгүй үг ашигласан, хэсгүүдийн хоорондын холболт ойлгомжгүй, ижил агуулга бүхий зохицуулах харилцааг өөр өгүүлбэрийн хэлбэрээр илэрхийж найруулгын алдаа гаргасан, үсгийн алдаа гаргасан гэх зохицуулалтыг сонгож авсан.

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
1.	Нэр томьёоны тайлбарт ойлгомжгүй байдал бий болгосон	-Журмын төслийн 2.2 дэх хэсэг "...орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдэж, үргэлжлэх хандлагатай болсон" гэх -Журмын төслийн 2.3 дахь хэсэг "...орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй буурсан, эсвэл хүн оршин сууж амьдрах нөхцөл байдалд эрс өөрчлөлт орсон" гэх
2.	Бичиглэл нь хууль тогтоомжийн тухай хуульд	-Журмын төслийн 6.3.1 дэх хэсэг "...(өвөлжөө, хаваржаа, зусландаа буух, отор нуудэл хийх

	нийцээгүй	зэргээр алслагдсан болон цаг үеийн хүндрэл зэргийг тооцож аль болох мэдээлэл авах, мөн хариу хэлэх боломжийг олгох)" гэх
3.	Тохиромжгүй үг ашигласан	-Журмын төслийн 6.4.1 дэх хэсэг "Үйл ажиллагаа..." гэх
4.	Хэсгүүдийн хоорондын холболт ойлгомжгүй	-Журмын төслийн 9.1 дэх хэсэг "Энэ журмыг зөрчсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, түүний төлөөлөгч, ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. Тухайлбал:..." гэх
5.	Ижил агуулга бүхий зохицуулах харилцааг өөр өгүүлбэрийн хэлбэрээр илэрхийлж найруулгын алдаа гаргасан	-Журмын төслийн 9.1.1-9.1.4 дахь хэсэг Тухайлбал: 9.1.1. Өөрчлөлтийн төслийг боловсруулахад алдаа гаргасан төрийн албан хаагч, мэргэжилтэн; 9.1.2. Өөрчлөлтийн төслийг иргэдэд мэдээлэх, таниулах, санаа бодлыг сонсох, нөлөөллийн үнэлгээг хийх, иргэдийн саналыг авах явцад зохион байгуулалтын алдаа гаргасан ажлын хэсгийн гишүүн; 9.1.3. Иргэдэд хэлэлцүүлэх, иргэдийн санал авах ажлыг санаатайгаар үймүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага; 9.1.4. Санал асуулгын дүнг холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг хоцроо, эсвэл дүнг санаатайгаар өөрчилсөн; -Журмын төслийн 9.1.5 дахь хэсэг "...Бусад..." гэх
6.	Үсгийн алдаа гаргасан	-Журмын төслийн 6.3.2 дэх хэсэг "...иргэдэд 45 хонгийн дотор цахим, хэвлэмэл, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ." гэх

2.4. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй, эсхүл шинээр бий болгож буй зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын

эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авдаг. Тус журмын төслийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх зан суртахуун болон онолын хувьд хүлээн зөвшөөрөхгүй, нийтээр ижил ойлгох харилцааг өөр байдлаар зохицуулсан гэх зохицуулалтыг сонгон авлаа.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Нийтээр дагаж мөрдөх зан суртахуун болон онолын хувьд хүлээн зөвшөөрөхгүй	<p>-Журмын төслийн 4 дэх хэсэг</p> <p>4. Нэгжийг тодорхойлох үзүүлэлт (шалгуур)</p> <p>4.1. Харьялах нэгжийн тоо, харьцаа ойролцоо байх</p> <p>4.1.1. Аймгийн сумын тоо, багийн тоо</p> <p>4.1.2. Нийслэлийн дүүрэг, хороо, хэсгийн тоо</p> <p>4.2. Нутаг дэвсгэрийн хувьд дараах үзүүлэлтийг харгалзана. Үүнд:</p> <p>4.2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээ зохистой, тэнцвэртэй байх</p> <p>4.2.2. Алслагдсан байдал: аймгийн төвөөс сум, баг хүртэлх зайд</p> <p>4.2.3. Төлөв: ердийн, алслагдсан, хилийн, төв суурин, орон нутгийн хот</p> <p>4.2.4. Хилийн цэс тодорхой байх</p> <p>4.3. Хүн амын нутагшил суурьшил, өсөлтийн дараах үзүүлэлтийг харгалзана. Үүнд:</p> <p>4.3.1. Хүн амын тоо, өсөлтийн хандлага (өсөлтийн хувь 1.05-аас дээш)</p> <p>4.3.2. Иргэд суурьшин амьдрах боломжтой байх (амьдрах нөхцөл, ажлын байр, өрхийн орлого)</p> <p>4.3.3. Хүн амын шилжих хөдөлгөөний татах/түлхэх хүчний харьцаа, хандлага</p> <p>4.4. Эдийн засгийн бүтэц</p> <p>4.4.1. Дэд бүтэц: зам тээврийн байдал, эрчим хүчний хангамж, усан хангамж, цэвэрлэх болон ариутгалын систем</p> <p>4.4.2. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ; Хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан, ой, бусад); Боловсруулах үйлдвэр; төрөл бүрийн үйлчилгээ нь зэрэг тодорхой бөгөөд хоршин ажиллах боломжтой байх (мезо түвшинд кластер үүсгэж байх; ДНБ-нд эзлэх болон оруулах хувь, хэмжээ тодорхой)</p> <p>4.5. Нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар</p> <p>4.5.1. Эрүүл мэндийн үйлчилгээ (сум, баг, өрхийн эмнэлэг, түргэн тусламж)</p> <p>4.5.2. Боловсрол (сургуулийн өмнөх, бага дунд)</p>

		боловсрол) 4.5.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 4.5.4. Нийгмийн бусад үйлчилгээ 4.6. Төрийн болон Нутгийн захиргааны ажил үйлчилгээ
2.	Нийтээр ижил ойлгох харилцааг өөр байдлаар зохицуулсан	-Журмын төслийн 6.5.1 дэх хэсэг "Орон нутгийн байнга оршин суугч иргэдээс санал асуулга авч, дүнг гаргана." гэх болон журмын 8.2 дахь хэсэг "Санал хураалтад тухайн нутагт байнга оршин суугч, сонгуулийн настын иргэдийн олонх (50 хувиас дээш) оролцсон бол санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцно." гэх

2.5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд журмын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

"Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгоходоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Энэхүү байдлаар шалгахад журмын төслөөс "Харилцан уялдаа" гэх шалгуурт нийцээгүй зүйл, заалтууд ажиглагдлаа. Тухайлбал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тухайн харилцааг зохицуулсантай зөрчилдөх, Захиргааны ерөнхий хуулийн агуулгатай зөрчилдөх, өөр зохицуулалттай хуулийг журмын зохицуулалттай хамааруулж зохицуулах, журам нь дотроо зөрчилдсөн зохицуулалт байна.

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл заалт
1.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тухайн харилцааг зохицуулсантай зөрчилдсөн	-Журмын төслийн 3.4 дэх хэсэг "...Төрийн суурь..." гэх -Журмын төслийн 1.1 дэх хэсэг "...(аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо)...", журмын төслийн 3.3 дахь хэсэг "...(Аймаг, сум алгассан байдлаар сум, дүүрэг, баг, хороо байгуулахгүй). ...", журмын төслийн 3.7 дахь хэсэг "...багийн төв ...", журмын төслийн 4.1.1 дахь хэсэг "...Аймгийн сумын тоо, багийн тоо...", журмын төслийн 4.1.2 дахь хэсэг "...Нийслэлийн дүүрэг, хороо, хэсгийн тоо...", журмын төслийн 4.2.2 дахь хэсэг "...баг хүртэлх зайд ...", журмын төслийн 4.5.1 дэх хэсэг "...(сум, баг, өрхийн эмнэлэг, түргэн тусlamж)...", журмын төслийн 4.5.2 дахь хэсэг "...(сургуулийн өмнөх, бага дунд боловсрол ...", журмын төслийн 5.1 дэх хэсэг "Баг, хороо, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар

		<p>иргэд болон Засаг дарга санал гаргаж болно. Баг, хорооны ИНХ, аймаг, нийслэлийн ИТХ саналыг тус тус хэлэлцэж, хурлаар гарсан шийдвэрийн дагуу ЗДТГ өөрчлөлтийн төслийг хийнэ”, журмын төслийн 5.4 дэх хэсэг “Баг, хорооны өөрчлөлтэй холбогдох төсөл, төсвийг боловсруулахад ЗДТГ-ын дэргэдэх Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж болон агентлагууд чиг үүргийн дагуу оролцож, уулзалт, хэлэлцүүлгийг хамтарч хийнэ.”, журмын төслийн 6.3.1 дэх хэсэг “Өөрчлөлтийн төслийг сум, багийн…”, журмын төслийн 6.5 дахь хэсэг “Ажлын хэсэг нь нэгжийн өөрчлөлтийн төсөлтэй холбоотой баг, хороо, сум, дүүргийн иргэдийн санаа бодлыг баг, хорооны ИНХ, сум, дүүргийн ИТХ-аар шатлан хэлэлцэж, дэмжсэн болон эс дэмжсэн учир шалтгааныг тэмдэглэж, албажуулна.”, журмын төслийн 6.5.2 дахь хэсэг “Баг, хорооны иргэдийн санал, асуулгын дүнг аймаг, дүүргийн ИТХ-д хүргүүлнэ”, хавсралт 1-ийн 1.2, 1.7, 1.8, 4.1, хавсралт 2-ийн 1 -Журмын 3.1 дэх хэсэг “Төрийн байгууламжийн нэгдмэл байх зарчим: Улс нь аймаг, нийслэлийг; аймаг нь сумаа; сум нь багаа; нийслэл нь дүүргээ, дүүрэг нь хороогоо зохион байгуулах бөгөөд хуулиар тогтоосон үүрэг, бүрэн эрхийн хүрээнд ажиллана (нэгжийн чиг үүрэг тодорхой, удирдлага шаталсан байх, түвшин тус бүрдээ шийдвэр гаргах эрх үүрэг, хариуцлагатай байх)”</p>
2.	Захиргааны ерөнхий хуулийн агуулгатай зөрчилдсөн	-Журмын төслийн 6.3 дахь хэсэг “…Орон нутгийн иргэдэд өөрчлөлтийн төслийг урьдчилан мэдэгдэнэ....” гэх
3.	Журам нь дотроо зөрчилдсөн	<p>-Журмын төслийн 2.6 дахь хэсэг “…Өөр аймагт...” гэх</p> <p>-Журмын төслийн 2.1-2.6 дахь хэсэг</p> <p>2.1. Нэгжийг өөрчлөх гэдэгт бодит нөхцөл байдал болон улс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж ЗЗНД-ийн нэгжийг шинээр байгуулах, татан буулгах, нэгтгэх, хуваах, шилжүүлэх зэргээр өөрчилж, харьяалал, нэр, нутаг дэвсгэрийн хэмжээ, хилийн цэсийг шинэчлэн тогтоох, иргэний бүртгэл, хаягийн хөдөлгөөн хийхийг ойлгоно.</p> <p>2.2. Нэгжийг шинээр байгуулах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдэж, ургэлжлэх хандлагатай болсон;</p>

		<p>2.3. Нэгжийг татан буулгах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй буурсан , эсвэл хүн оршин сууж амьдрах нөхцөл байдалд эрс өөрчлөлт орсон;</p> <p>2.4. Нэгжийг нэгтгэх гэж зэргэлдээх нэгжүүдийг нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд нэгтгэх;</p> <p>2.5. Нэгжийг хуваах гэж нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд хуваах;</p> <p>2.6. Нэгжийг шилжүүлэх гэж бус нутгийн хөгжлийн таталцалтай уялдуулж тухайн нэгжийг өөр аймагт нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд харьялуулах;</p>
--	--	--

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ЖУРМЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрт нийцсэн дараах шалгах хэрэгсэл байна. Эдгээр шалгах хэрэгсэл нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтэд нийцсэн боломжтой арга, хэрэгсэл юм.

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төлийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Журмын төслийн 1.1 дэх хэсэг болон журам бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Журмын төслийн 6.3.1 дэх хэсэг, журмын төслийн 6.3.2 дэх хэсэг, журмын төслийн 6.5 дахь хэсэг, журмын төслийн 8.1 дэх хэсэг	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3.	Ойлгомжтой байдал	Журмын төслийн 2.2 дэх хэсэг, журмын төслийн 2.3 дахь хэсэг, журмын төслийн 6.3.1 дэх хэсэг, журмын төслийн 6.4.1 дэх хэсэг, журмын	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай

		төслийн 9.1 дэх хэсэг, журмын төслийн 9.1.1-9.1.4 дахь хэсэг, журмын төслийн 9.1.5 дахь хэсэг, журмын төслийн 6.3.2 дэх хэсэг	хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах, мөн бусад баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар судлах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Журмын төслийн 4 дэх хэсэг, журмын төслийн 6.5.1 дэх хэсэг журмын төслийн 8.2 дахь хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийхасуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх
5.	Харилцан уялдаа	-Журмын төслийн 3.4 дэх хэсэг, журмын төслийн 1.1 дэх хэсэг, журмын төслийн 3.3 дахь хэсэг, журмын төслийн 3.7 дахь хэсэг, журмын төслийн 4.1.1 дахь хэсэг, журмын төслийн 4.1.2 дахь хэсэг, журмын төслийн 4.2.2 дахь хэсэг, журмын төслийн 4.5.1 дэх хэсэг, журмын төслийн 4.5.2 дахь хэсэг, журмын төслийн 5.1 дэх хэсэг, журмын төслийн 5.4 дэх хэсэг, журмын төслийн 6.3.1 дэх хэсэг, журмын төслийн 6.5 дахь хэсэг, журмын төслийн 6.5.2 дахь хэсэг, хавсралт 1-ийн 1.2, 1.7, 1.8, 4.1, хавсралт 2-ийн 1, журмын төслийн 6.3 дахь хэсэг, журмын төслийн 2.6 дахь хэсэг, журмын 2.1-2.6 дахь хэсэг, журмын 3.1 дэх хэсэг	Харилцан уялдааг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах, мөн бусад баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар судлах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу журмын төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэхээр тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төслийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд журмын төсөл бүхэлдээ болон журмын төслийн зорилго хэсэг буюу 1.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийнэ.

Журмын төсөл нь бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэхэд журмыг бүхэлд нь дүгнэж дүн шинжилгээ хийсэн байдал.

Зорилгын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудал нь Үндсэн хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн зорилгод нийцсэн байх ёстой. Мөн тус асуудал нь Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн түүхэн асуудлуудын нэг юм.

1992 оны Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж өөрчлөх асуудлыг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэж зохицуулсан. Энэхүү зохицуулалт нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнө "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэх зохицуулалттай байжээ. Одоогийн байгаа зохицуулалт нь өмнөх зохицуулалтаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхдөө тухайн нутгийн хурлын саналыг үндэслэхийг болиулсан, Засгийн газар өргөн мэдүүлдэг болсон зэргээр өөр байна.

Тус Үндсэн хуулийн зохицуулалтын талаар тайлбарласан олон тайлбарууд байдаг. Тухайлбал, "Аймаг, нийслэл, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутгийн иргэд, Хурлаас гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн бүтэц, байгаль, газар зүй, зам харилцааны нөхцлийг харгалзан боловсруулж Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Баг хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийг баримтлан тухайн аймаг, нийслэлийн Хурал хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ²." гэх байдлаар тайлбарласан байна. Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхдөд наанадаж харьяат хүн бүрийн бичиг баримтаас өгсүүлээд тэдгээрийн хувийн хийгээд үйлчлүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, данс бүртгэл, хувь хүн, хуулийн этгээдээс түмэн зүйлийн байгууллагатай тогтоосон хэвийн харилцаа эvdэгдэн, өөрчлөгдж, үлэмжхэн чирэгдэл гардаг. Цаанадаж алсдаа түүх "төөрөлддөг". Үндсэн хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн гол зарчим, үндсэн бүтцийг тогтоосон нь төрийн байгууламж, иргэдийн аж амьдралын орчинг тогтвортой байлгах зорилготой. Хэрэв түүнийг өөрчлөх хэмээвээс Үндсэн хуулийн заалтыг өөрчлөхөд хүргэнэ. Харин аль нэг аймаг, сум, баг буюу дүүрэг, хорооны нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх, эсвэл холбогдох нэгжийг татан буулгах, шинээр буюу өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, салгах)-д дээрх зарчим үйлчилнэ. Иймд тодорхой нэгж, түүний нутаг дэвсгэрийн цэсийг өөрчлөх хэрэгцээ, шаардлага

² Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар", (УБ, 2000), 232 дахь тал

гарвал УИХ та бидний саналыг үндэс болгон шийдвэрлэж байхаар Үндсэн хуульд заасан байна³.

Мөн энэ талаар Үндсэн хуулийн маргаан үүсч байсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хамгийн анхны шийдвэр нь байсан. "Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай Монгол Улсын Их Хурлын 1992 оны 08 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 01 дугаарт дүгнэлт гарсан ба "Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолыг боловсруулах, батлах явцдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ" гэсэн заалтын шаардлагыг хангаагүй байх буюу Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн тогтоол байх тухай дүгнэсэн. Үүний дараа Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдаан хуралдаж "Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай Монгол Улсын Их Хурлын 1992 оны 08 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" дугаар 01 тогтоолыг гаргасан ба ""Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтын 3 дахь хэсгийг хэвээр үлдээж, бусад заалтыг хүчингүй болгосугай." гэж шийдвэрлэсэн.

Тус Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн маргааны агуулга болон үндэслэлийг товчхон авч үзвэл хот, хороодыг сумдад нэгтгэхдээ эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслээгүй тус шийдвэрийг Улсын Их хурал гаргасантай холбоотой шийдвэр байна. Мэдээлэл гаргагч тал болон гомдол гаргагч талын хувьд ч тухайн асуудал дээр маргаан үүсгэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэц үүнийг дээрх байдлаар шийдвэрлэжээ. Үндсэн хуулийн шийдсэн шийдвэрийн гол үндэслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд эдийн засаг, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн хурал, иргэдийн саналыг үндэслэн шийдвэрлэх заалтыг хангаагүй байна⁴ гэж үзсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харилцааг зохицуулах органик хууль болох "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хууль 2020 онд батлагдсан байна. Тус хуулийн 13 дугаар зүйлд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг зохицуулсан байна. Ингэхдээ аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэх, аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачлах, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх

³ Б.Чимиid, "Үндсэн хуулийн мэдлэг", (УБ, 2008), 356-357 дахь тал

⁴ С.Номынбаясгалан, "Үндсэн хуулийн маргаан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг", (УБ, 2018), 74 дэх тал

асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авах, санал авах ажлыг харьяалах иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулах бөгөөд санал авах журмыг Улсын Их Хурал тогтоох, санал хураалтад сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх оролцсон бол уг санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцохоор тус тус зохицуулсан байна.

Өмнөх хууль буюу 2006 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд дээрхээс өөрөөр буюу "Аймаг, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэж зохицуулж байжээ.

Энэ талаар тухайн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээнд "УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат ЗЗНД-ийн хуваарийг эдийн засгийн үр ашгийн үүднээс харж шинэчлэхийн чухлыг "Засаг захиргааны хуваарияа өөрчлөх асуудал сүүлийн хорин жилд нэг бус удаа хөндөгдөх байсан ч тухайн үеийн эрх баригчид зориглоогүй. Хамгийн гол шалтгаан нь засаг захиргааны хуваарийг юунд үндэслэн яаж өөрчлөх вэ гэдэгт өнөөдрийг хүртэл оновчтой концепци олж чадаагүйд учир бий. Одоо эдийн засгийн бүсчилсэн хөгжилтэй холбож засаг захиргааны нэгжийн хуваарийг тогтоох шаардлагатай. Өнөөдөр чөлөөт зах зээлийн эдийн засаг хөгжихгүй байгаагийн гол үндэс нь 330 сум. Яагаад? Зах зээлийн хуулиар бол хүн амын нягтрал талаас нэг ам км газар нутагт 10 хүн суурьшиж байж тэнд зах зээл үүсдэг байна. Дор хаяж ийм тохиолдолд талх барьж зарах нь ашигтай болно. Тэгвэл өнөөдөр Өмнөговь аймагт нэг квадрат км-т 0.3 хүн, Дорноговь аймагт 0.5 хүн, Говь-Алтай аймагт 0.4 хүн суурьшиж байна. Статистик харвал зах зээл үүсэх наад захын нөхцөлгүй аймаг, сумын тоо ийм байдлаар үргэлжилж байснаа цөөхөн хэдэн хот сууринд даац нь хэтрээд явчихаж байна. Орхон аймаг буюу Эрдэнэтэд нэг ам км газар нутагт 107 хүн, нийслэл Улаанбаатар хотод 245 хүн суурьшиж байх жишигтэй. Чөлөөт худалдаа, эдийн засаг, зах зээлийн харилцаа үүсэх ямар ч орчин, нөхцөл байхгүй 330 суманд иргэд эдийн засгийн баталгаагүй, эрх мэдэлгүй, эрх чөлөөгүй амьдарч байна" гэжээ. Үндсэн хуульд ЗЗНДН-ийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн УИХ шийдвэрлэнэ (57.3) гэж заасны дагуу ЗЗНДНТУХ-д сум байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд болон ИТХ-аас гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан байна.

Үндсэн хуулийн ийм хамгаалалт байхгүй орнуудад, тухайлбал, Англид нутаг дэвсгэрийн нэгжүүд, тэр ч байтугай, засаг захиргааны нэг шатыг бүхлээр нь төв засгийн газар нь татан буулгадаг байдал гарч хуулийн хамгаалалт бий болгохоор идэвхийлэн яригдаж байна.²³ Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартийн 5 дугаар зүйлд нутгийн эрх барих байгууллагын хил хязгаарыг тухайн нутаг дэвсгэрт оршин суух иргэдтэй урьдчилан зөвлөхгүйгээр өөрчлөхгүй байх, бололцоотой нөхцөлд хэрэв хуульд заасан бол орон нутгийн санал асуулга явуулах замаар шийдвэрлэж байх тухай заажээ. ЗЗНДНТУХ-д, нэг талаас сумын

иргэдийн саналыг ямар шийдвэр дээр үндэслэн хэн, хэрхэн авах, иргэдийн болон ИТХ-ын санал зөрсөн тохиолдолд хэрхэх гэх мэт процедур агуулсан “үндэслэх” зохицуулалтыг дутуу хийжээ. Иймээс ЗЗНДН-ийг татан буулгах шийдвэрийг иргэд нь дэмжсэн байхад Засаг дарга, Хурлын дарга, Хурлын төлөөлөгч цөөн хүн албан тушаалаа хадгалах зорилгоор дэмждэггүй, Хурлаас гарсан шийдвэр нь шүүх дээр очоод процедур зөрчсөн үндэслэлээр хүчингүй болдог тохиолдууд гарсаар байна. Нутаг дэвсгэрийн нэгжийг татан буулгах асуудлыг орон нутгийн санал асуулга явуулах замаар шийдвэрлэдэг, энэ тохиолдолд санал асуулгын дүнг Хурал эцсийнх гэж хүлээн зөвшөөрдөг, эсхүл ЗЗНДН-үүдийг нэгтгэх саналыг дэмжсэн иргэдийн тоог тодорхой заадаг (Эстонд 5000 хүн дэмжсэн байх шаардлага тавьсан) олон улсын туршлага байна. Нөгөө талаас, “хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл” гэх “харгалзах” заалт нь тодорхой бус, барьцгүй, субъектив шинжтэй байна. Жишээлбэл, эдийн засгийн чадавхийг харгалзана гэвэл өнөөдөр улсын төсвийн дэмжлэг дээр оршин тогтнодог бүх сум энэ шалгуураар татан буугдах болно. Хүн амын байршил гэдэгт юг ойлгох нь тодорхойгүй байна. Бидний судалсан бусад улсуудын нутгийн удирдлагын тухай хуульд хүн амын тооны доод хязгаарыг ЗЗНДН-ийн гол шалгуур болгожээ. Тухайлбал, Турк Улсын муниципаль актад 5000-аас дээш хүн амтай бол муниципаль нэгж байгуулах эрхтэй, харин муниципаль нэгжийн хүн амын тоо 2000-с доош болсон тохиолдолд тосгон болгож зохион байгуулах, түүний хуулийн этгээдийн статусыг цуцлах тухай заажээ. Францын хуульд ч үүнтэй төстэй зохицуулалт байна. Дани Улсад нутаг дэвсгэрийн шинэчлэлийг хоёр үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлсэн нь 1962-1970 онд муниципаль нэгжийн тоог 1388-аас 275, 2003-2007 онд 275-аас 98, регионы тоог 25-14, 14-5 тус тус болгож цөөлсөн байна. Нутаг дэвсгэрийн нэгжүүдийг сайн дурын үндсэн дээр нэгтгэх оролдлого ямар ч үр дүнд хүрэхгүй гэдэг үндсэн дээр төв засгийн газар нутаг дэвсгэрийн нэгжүүдийг нэгтгэх үйл ажиллагаанд хожим эсэргүүцэлтэй тулахгүйн тулд тэднийг эхнээс нь оролцуулах буюу холимог загвараар шийджээ.

Ийнхүү холимог аргаар хийх нь хамгийн үр дүнтэй, бидэнд бусад оронд энэ шинэтгэлийг хэрхэн хийх талаар зөвлөх арвин туршлага бий гэж тэмдэглэсэн байна.²⁴ Английн парламент ч энэ туршлагыг тусгайлан судалжээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэн орнууд шинэтгэлийн үр дүнд хүн амд суурь үйлчилгээг хүргэх, шинээр тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх чадавхитай, хүчтэй нутгийн удирдлага бий болсон тухай тэмдэглэжээ⁵.“ гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинээр зохион байгуулах асуудал болон түүнд харгалзаж үзэх асуудлыг авч үзжээ.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай дараах тайлбар байна. Энэ нь зорилгыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

13 дугаар зүйлийн 1-ийн тухай тайлбар.

Юуны түрүүнд өмнө нь мөрдөж ирсэн хуульд тусгагдсан “нийслэл” гэсэн үг энд ороогүй нь нийслэлийг өөрчлөх асуудлыг нийслэлийн эрх зүйн байдлыг зохицуулсан хуульд тусгах, цаашлаад тусгайлсан хууль гаргахыг шаардах асуудал

⁵ Д.Батбаатар, Ш.Бямбаа, Д.Ганзориг, Б.Гүнбилэг, Ц.Даваадулам, Г.Жаргал, Н.Лувсанжав, Р.Мухийт, Д.Сүнжид “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, (УБ, 2019), 30 дахь тал

хэмээн үзсэнтэй холбоотой юм. Аймаг, сум, дүүргийг өөрчлөхөд асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлэх, эдийн засгийн бүтэц, чадавхийн хувьд харьцангуй бие даан хөгжих ирээдүйтэй эсэх, хүн амын тоо, газар зүйн байршил, иргэдийн санал зэргийг тэргүүн ээлжинде харгалzan үзэхийн зэрэгцээ, тэдгээртэй холбоо бүхий зам харилцааны нөхцөл, улс орныг батлан хамгаалах, хил хамгаалах бодлого, түүхэн уламжлал, үндэстэн, ястны нутагшил, бэлчээр, усыг ашиглаж ирсэн уламжлал зэргийг давхар тооцож үзэх нь зүйтэй юм. Түүнчлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэхээр заасан байгаа нь нийслэлд оршин суудаг тухайн нутгийн угуул иргэд энэ чиглэлээр саналын эрх эдлэхгүй гэдгийг тодотгосон болно. Нэгжийг өөрчлөх шийдвэр гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр өмнө нь мөрдөж байсан иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэх зохицуулалтыг өөрчилсөнтэй холбогдуулан ийнхүү зохицуулсан болно.

13 дугаар зүйлийн 2-ийн тухай тайлбар.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг Засгийн газраас санаачилж, Улсын Их Хурал шийдвэрлэхээр тусгасан нь уг асуудлын ач холбогдлыг илэрхийлэхийн зэрэгцээ, хуулийн эдгээр үндэслэл, бусад харгалzan үзэх хүчин зүйлийг ултай судалж, судалгаа, тооцоонд үндэслэн туйлын анхаарал, болгоомжтой хандах хэрэгтэй гэдгийг давхар анхааруулж байгаа хэрэг юм.

13 дугаар зүйлийн 3-ийн тухай тайлбар.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхийн өмнө тухайн өөрчлөлттэй холбогдох нэгжийн иргэдийн саналыг авах журмыг Улсын Их Хурал тогтоох, санал авах ажлыг үр дүнг хүчинтэйд тооцоход тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа иргэдийн олонхи нь хамрагдсан байхыг шалгуур болгон тогтоосноор нэгжийг өөрчлөх харилцааг тодорхой болгон зохицуулсан. Нэгжийг өөрчлөх үндэслэл, өөрчилсний дараах үр өгөөжийн талаар иргэдэд тайлбарлан таниулах ажлыг иргэдийн саналыг авахын өмнө Засгийн газраас зохих түвшинд гүйцэтгэх нь Улсын Их Хурлаас энэ талаар шийдвэр гаргах нэг нөхцөл болох юм. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас батлан гаргах иргэдийн санал авах журамд Засгийн газраас иргэдэд холбогдох өөрчлөлтийн талаар тайлбарлан таниулах ажлын дараалал, журам, нэгжийг өөрчилсний дараах эдийн засгийн дэвшил, бие даан хөгжих ирээдүй, дээр дурдсан иргэдийн оролцооны босго, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг дордуулахгүй байх, иргэдийн санал авах ажлыг холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулах дараалал, журам зэргийг заавал тусгах хэрэгтэй болно⁶.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар оролцогч талуудын санал авах журам”-ын төсөл нь нийтлэг үндэслэл, журмын хүрээнд хэрэглэх нэр томьёо, баримтлах зарчим, нэгжийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, нэгжийг өөрчлөхөд талуудын үүрэг, оролцоо, ажлын хэсгийн үүрэг, үйл ажиллагаа, иргэдийн санал авах, дүнг нэгтгэж мэдээллэх, хариуцлага гэх бүлгүүдэд хуваагдаж тухайн харилцааг зохицуулсан байна. Тус журмын төслийн бүлэг болгоныг тус бүрт нь авч зорилгодоо нийцсэн эсэхийг судлан үзье.

⁶ 2020 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 51-52 дахь тал

Нийтлэг үндэслэл гэх бүлгийн тухайд 3 төрлийн харилцааг зохицуулж байгаа бөгөөд дээр дурдсан зорилгуудтай зөрчилдсөн зүйл байхгүй байна. Мөн журмын төслийг 1.1 дэх хэсгийг дараагийн хэсэгт дүн шинжилгээ хийх болно.

Журмын хүрээнд хэрэглэх нэр томьёо гэх бүлгийн тухайд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхтэй холбоотой нэр томьёонуудыг тайлбарласан учир дээрх зорилготой нийцэж байна.

Баримтлах зарчим гэх бүлгийн хүрээнд тус журамд баримтлах 7 зарчмыг тусгасан ба тус 7 зарчим нь зорилгод нийцсэн буюу түүнийг гүйцэлдүүлэх зорилготой байна.

Нэгжийг тодорхойлох шалгуур үзүүлэлт бүлэг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan шийдвэрлэх зорилгыг нарийвчилж зохицуулсан учир зорилгод нийцэж байна.

Нэгжийг өөрчлөх асуудалд талуудын үүрэг, оролцоо гэх бүлэгт баг, хорооны ИНХ, аймаг, нийслэлийн ИТХ-ийн саналыг авах, ЗДТГ-ын дэргэдэх Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, Яам, Агентлаг, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газрын саналыг авах зэрэг харилцааг зохицуулсан нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхөд эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan шийдвэрлэх зорилгыг нарийвчилж зохицуулсан учир зорилгод нийцэж байна.

Ажлын хэсгийн үүрэг, үйл ажиллагаа гэх бүлэг нь иргэдээс санал авах зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд процессын зохицуулалтыг агуулсан тул зорилгodoо нийцсэн байна.

Иргэдийн санал авах, дүнг нэгтгэж мэдээлэх бүлэг нь мөн дээрхийн адил процессын асуудлыг шийдсэн тулд процессын зохицуулалтыг агуулсан тул зорилгodoо нийцсэн байна.

Хариуцлага гэх бүлэг нь хууль зайлшгүй биелэгдэх зарчмын үүднээс тус зорилгыг биелүүлэх агуулгатай учир тус зохицуулалт нь зорилгodoо нийцсэн байна.

Журмын төслийн зорилго нь Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зорилгод нийцсэн эсэхэд журмын төслийн 1.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал

Журмын төслийн 1.1 дэх хэсэгт журмын зорилгыг "Энэ журмын зорилго нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн (аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо) өөрчлөлтийг санаачлах, төлөвлөх, зохион байгуулах, оролцогч талуудын саналыг авах, тусгахад чиглэнэ." гэж тодорхойлсон байна. Үүнийг зорилтын түвшинд авч үзвэл дараах байдалтай байна.

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг санаачлах
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг төлөвлөх
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг зохион байгуулах
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй холбоотой оролцогч талуудын саналыг авах, тусгах

4 дэх зорилтын тухайд өмнөх хэсэгт зорилгод нийцэж байгаа гэдгийг тодорхойлсон. Эхний 3 зорилтын тухайд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг

өөрчлөхөд санал авах зорилгыг өөрчлөлтийг санаачлах, төлөвлөх, зохион байгуулахгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй учир үүнийг зорилгodoо нийцсэн гэж үзэж байна. Гэвч “аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо” гэж зохицуулсны нийслэл, хороо, баг гэж зохицуулсан нь зорилгод нийцэхгүй байна. Учир нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хувьд тус журмын зорилго нь зөвхөн аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудалд хамаарч байхаар зохицуулсан. Тиймээс тус журмын төслийн зорилго хэсэгт зохицуулах харилцаанд хамааралгүй “...нийслэл, баг, хороо...” гэх зохицуулалтыг хасах нь зүйтэй.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” гэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд туршилтийн ажиллагааг явуулахдаа тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалттай холбоотой тодорхой тохиолдлыг бий болгож туршилтын ажиллагаа зохион байгуулна. Энэхүү хүрээнд журмын төслийн 6.3.1, 6.3.2, 6.5, 8.1 дэх хэсэгт заасан зохицуулалтад дүн шинжилгээ хийнэ. Ингэхдээ баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн болно.

Иргэдэд өөрчлөлтийн төслийг мэдэгдэхтэй холбоотой зохицуулалтууд болох журмын төслийн 6.3.1, 6.3.2 дахь хэсгүүд практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Журмын төслийн 6.3.1-т “Өөрчлөлтийн төслийг сум, багийн иргэдэд 3 сарын дотор хэвлэмэл танилцуулга, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ (өвөлжөө, хаваржаа, зусландаа буух, отор нүүдэл хийх зэргээр алслагдсан болон цаг үеийн хүндэрэл зэргийг тооцож аль болох мэдээлэл авах, мөн хариу хэлэх боломжийг олгох.)” гэж зохицуулжээ. Мөн 6.3.2-т “6.3.2. Өөрчлөлтийн төслийг дүүрэг, хорооны иргэдэд 45 хонгийн дотор цахим, хэвлэмэл, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ.” гэх байдлаар зохицуулжээ. Дээрх хоёр зохицуулалтын нийтлэг зүйл нь тодорхой хоногийн дотор өөрчлөлтийн төслийг иргэдэд мэдэгдэхтэй холбоотой байна. Гэхдээ хоногийн дотор гэж хугацааг зааж зохицуулахдаа ямар үйл ажиллагаанаас хойш тухайн хоногийн дотор гэдгийг зохицуулаагүй үлдээсэн байна. Тухайлбал, ажлын хэсэг байгуулагдсанаас хойш, өөрчлөлтийн төслийг боловсруулснаас хойш гэх мэтчилэн тухайн хугацааг эхлэх хоногийг зааж өгөх нь зүйтэй байжээ.

Тиймээс тухайн журмын төслийн 6.3.1, 6.3.2 дахь хэсэг нь практикт хэрэгжих боломжгүй байна. Учир нь ажлын хэсэг иргэдэд өөрчлөлтийн төслийг мэдэгдэхдээ ямар хугацаанд мэдээллэх нь тодорхойгүй болж байна.

Журмын иргэдээс санал авах үйл ажиллагааны үе шаттай холбоотой зохицуулалт болох журмын төслийн 6.5 дахь хэсэг практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 6.5 дахь хэсэг “Ажлын хэсэг нь нэгжийн өөрчлөлтийн төсөлтэй холбоотой баг, хороо, сум, дүүргийн иргэдийн санаа бодлыг баг, хорооны ИНХ, сум, дүүргийн ИТХ-аар шатлан хэлэлцэж, дэмжсэн болон эс дэмжсэн учир шалтгааныг тэмдэглэж, албажуулна.” гэж зохицуулсан. Үүний дэд заалтууд болох 6.5.1-т “Орон нутгийн байнга оршин суугч иргэдээс санал асуулга авч, дүнг гаргана.”, 6.5.2-т “Баг, хорооны иргэдийн санал, асуулгын дүнг аймаг, дүүргийн

ИТХ-д хүргүүлнэ.", 6.5.3-т "Сум, дүүргийн иргэдийн санал, асуулгын дунг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ." гэх заалтууд байна. Тухайн заалтууд нь иргэдээс санал авах процессыг зохицуулах заалтууд ба дараалалсан үйл явц байхаар харагдаж байна. Тодруулбал дараах байдалтай байвал тохиромжтой байжээ.

-"6.5. Ажлын хэсэг нь нэгжийн өөрчлөлтийн төслийн талаарх иргэдийн саналыг дараах байдлаар авна.

6.5.1.Нэгжийн өөрчлөлтийн төсөлтэй холбоотой баг, хороо, сум, дүүргийн иргэдийн санаа бодлыг баг, хорооны ИНХ, сум, дүүргийн ИТХ-аар шатлан хэлэлцэж, дэмжсэн болон эс дэмжсэн учир шалтгааныг тэмдэглэж, албажуулна.

6.5.2.Орон нутгийн байнга оршин суугч иргэдээс санал асуулга авч, дунг гаргана.

6.5.3.Баг, хорооны иргэдийн санал, асуулгын дунг аймаг, дүүргийн ИТХ-д хүргүүлнэ.

6.5.4.Сум, дүүргийн иргэдийн санал, асуулгын дунг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Ингэснээр тус зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой болохоор байна. Учир нь иргэдээс санал авах үйл ажиллагааны дараалал, хийх ажил нь тодорхой болж байна.

Иргэдээс санал авахтай холбоотой зохицуулалтууд болох журмын төслийн 8.1 дэх хэсэг практикт хэрэгжих боломжтой эсэхэд дун шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 8.1 дэх хэсэгт "Нэгжийг өөрчлөх асуудлын талаар орон нутгийн иргэдээс өөрчлөлтийг "дэмжиж байна", "дэмжихгүй" гэсэн хоёр санал авна." гэж зохицуулсан байна. Гэвч тухайн "дэмжиж байна", "дэмжихгүй" гэсэн саналыг хэрхэн авахыг тодорхойлж өгөөгүй байна. Тиймээс үүнийг тодорхой, практикт хэрэгжих боломжтой болгохын тулд хавсралтаар санал авах загварыг баталсан нь зүйтэй.

3.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Журмын төслийн зүйл, заалт, зохицуулалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэхийг нарийвчлан шалгана. Ингэхдээ журмын төслийн 2.2, 2.3 дахь хэсэг, 6.3.1 дэх хэсэг, 6.4.1 дэх хэсэг, 9.1 дэх хэсэг, 9.1.1-9.1.4 дэх хэсэг, 6.3.2 дахь хэсгүүдэд дун шинжилгээ хийсэн болно.

Нэр томъёоны тайлбарт ойлгомжгүй байдал бий болгосон зохицуулалтууд болох журмын төслийн 2.2, 2.3 дахь хэсгийн ойлгомжтой байдалд дун шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 2.2-т "Нэгжийг шинээр байгуулах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдэж, үргэлжлэх хандлагатай болсон", 2.3-т "Нэгжийг татан буулгах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй буурсан , эсвэл хүн оршин сууж амьдрах нөхцөл байдалд эрс өөрчлөлт орсон" гэж зохицуулсан. Тус заалтын тухайд журмын нэр томъёоны тухай агуулгатай зохицуулалт учир тодорхойлолт нь оновчтой байх ёстой. Тус хоёр зохицуулалтын

хувьд нийтлэг зүйл нь үйл үг буюу хэл зүйн хувьд тодорхой нэг зүйлийг хийх утгатай нэр томьёог нэрлэсэн найруулгын хэлбэрээр зохицуулсан байна. Тиймээс найруулгын алдаа үүсч тухайн зохицуулалт нь ойлгомжгүй болж байна. Үүнийг дараах байдлаар зохицуулах нь зүйтэй.

-Журмын төслийн 2.2 дахь хэсэг “Нэгжийг шинээр байгуулах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдэж, үргэлжлэх хандлагатай болсныг үндэслэн шинээр байгуулах”

-Журмын төслийн 2.3 дахь хэсэг “Нэгжийг татан буулгах гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй буурсныг үндэслэн тухайн нэгжийг хасах”

Ийнхүү зохицуулснаар найруулгын хувьд алдаагүй болж, ойлгомжтой байдлыг бий болгоно.

Бичиглэл нь хууль тогтоомжийн тухай хуульд нийцээгүй зохицуулалт болох журмын төслийн 6.3.1 дэх хэсгийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 6.3.1 дэх хэсэгт “Өөрчлөлтийн төслийг сум, багийн иргэдэд 3 сарын дотор хэвлэмэл танилцуулга, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ (өвөлжөө, хаваржкаа, зусландаа буух, отор нүүдэл хийх зэргээр алслагдсан болон цаг үеийн хүндрэл зэргийг тооцож аль болох мэдээлэл авах, мөн хариу хэлэх боломжийг олгох).” гэж зохицуулсан байна. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хаалтыг тухайн тохиолдолд хэрэглэхээр зохицуулаагүй байна. Мөн үүнээс гадна тус агуулгыг хаалтнаас гадна тусдаа зохицуулалт болгон хуульчлах нь ойлгомжтой байна. Ингэхдээ тус хэсэгт өвөлжөө, хаваржкаа, зусландаа буух, отор нүүдэл хийх зэргээр алслагдсан болон цаг үеийн хүндрэл зэргийг тооцож аль болох мэдээлэл авах, мөн хариу хэлэх боломжийг олгох нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй гэх зохицуулалтыг оруулах нь илүү ойлгомжтой болгохоор байна.

Тохиромжгүй үг ашигласан зохицуулалт болох журмын төслийн 6.4.1 дэх хэсгийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 6.4.1 дэх хэсэгт “Үйл ажиллагаа болон эрх нь зөрчигдэж болзошгүй талуудтай уулзаж” гэх зохицуулалтыг оруулсан байна. Энэхүү хэсгийн “Үйл ажиллагаа” гэх үгийн сонголт нь тохиромжгүй байна. Учир нь үйл ажиллагаа зөрчигдэх гэсэн ойлголт нь логикин алдаатай болж байна. Үүний оронд үйл ажиллагаанд нь саад учрах гэх байдлаар найруулсан нь ойлгомжтой байдлыг бий болгож байна.

Хэсгүүдийн хоорондын холболт ойлгомжгүй зохицуулалт болох журмын төслийн 9.1 дэх хэсгийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 9.1 дэх хэсэгт “Энэ журмыг зөрчсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, түүний төлөөлөгч, ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. Тухайлбал:” гэх зохицуулалт байна. Тухайлбал гэх үг нь бусад хууль тогтоомжид огт хэрэглэгддэггүй нэр томьёо байна. Тиймээс Хууль тогтоомжийн

тухай хуулийн 30.1.1-т заасан “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх” гэх шалгуурт нийцэхгүй байна. Иймд тухайн зохицуулалт нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Тиймээс үүний тодорхой болгохын тулд Журмын төслийн 9.1 дэх хэсгийг “Энэ журмыг зөрчсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, түүний төлөөлөгч, ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол дараах үйлдлүүдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчилж зохицуулах нь ойлгомжтой байдлыг бий болгохоор байна.

Ижил агуулга бүхий зохицуулах харилцааг өөр өгүүлбэрийн хэлбэрээр илэрхийлж найруулгын алдаа гаргасан зохицуулалт болох журмын төслийн 9.1.1-9.1.4 дэх хэсгийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 9.1.1-9.1.4 дэх хэсэгт дараах зохицуулалтыг тусгасан байна.

9.1.1. Өөрчлөлтийн төслийг боловсруулахад алдаа гаргасан төрийн албан хаагч, мэргэжилтэн;

9.1.2. Өөрчлөлтийн төслийг иргэдэд мэдээлэх, таниулах, санаа бодлыг сонсох, нөлөөллийн үнэлгээг хийх, иргэдийн саналыг авах явцад зохион байгуулалтын алдаа гаргасан ажлын хэсгийн гишүүн;

9.1.3. Иргэдэд хэлэлцүүлэх, иргэдийн санал авах ажлыг санаатайгаар үймүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага;

9.1.4. Санал асуулгын дүнг холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг хоцроох, эсвэл дүнг санаатайгаар өөрчилсөн;

Тус зохицуулалт нь хариуцлага хүлээх үйлдлүүдийг журамласан зохицуулалт байна. Харин 9.1.1-9.1.3-т үйлдлийг бус албан тушаалтан, оролцогчийг зохицуулсан байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгосон байна. Тиймээс тухайн албан тушаалтан, оролцогчийн үйлдлийг давхар зохицуулах нь зүйтэй. Дараах байдлаар зохицуулах нь ойлгомжтой байдлыг бий болгохоор байна.

9.1.1. Төрийн албан хаагч, мэргэжилтэн өөрчлөлтийн төслийг боловсруулахад алдаа гаргасан;

9.1.2. Ажлын хэсгийн гишүүн өөрчлөлтийн төслийг иргэдэд мэдээлэх, таниулах, санаа бодлыг сонсох, нөлөөллийн үнэлгээг хийх, иргэдийн саналыг авах явцад зохион байгуулалтын алдаа гаргасан;

9.1.3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд хэлэлцүүлэх, иргэдийн санал авах ажлыг санаатайгаар үймүүлсэн;

Үсгийн алдаа гаргасан зохицуулалт болох журмын төслийн 6.3.2 дахь хэсгийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Журмын төслийн 6.3.2-т “Өөрчлөлтийн төслийг дүүрэг, хорооны иргэдэд 45 хонгийн дотор цахим, хэвлэмэл, уулзалт зэрэг хэлбэрээр мэдэгдэнэ.” гэж зохицуулсан байна. Тус хэсгийн “хонгийн” гэх үг нь зөв бичих дүрмийн хувьд алдаатай бичигдсэн байна. Тиймээс тус журмын “хонгийн” гэдгийг “хоногийн” гэж өөрчлөх шаардлагатай байна.

3.4. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт их хүндрэл үүсгэх зохицуулалт байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож, хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг хийх нь зүйтэй. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд Журмын төслийн 4 дэх хэсэг, журмын төслийн 6.5.1 дэх хэсэг журмын төслийн 8.2 дахь хэсэг гэх зохицуулалтад дүн шинжилгээг хийж "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгсөн.

Нийтээр дагаж мөрдөх зан суртахуун болон онолын хувьд хүлээн зөвшөөрөхгүй зохицуулалт болох журмын төслийн 4 дэх хэсэг хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Журмын төслийн 4 дэх хэсэгт нэгжийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг зохицуулсан ба дараах байдлаар зохицуулагдсан байна.

4. Нэгжийг тодорхойлох үзүүлэлт (шалгуур)

4.1. Харьялах нэгжийн тоо, харьцаа ойролцоо байх

4.1.1. Аймгийн сумын тоо, багийн тоо

4.1.2. Нийслэлийн дүүрэг, хороо, хэсгийн тоо

4.2. Нутаг дэвсгэрийн хувьд дараах үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

4.2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээ зохистой, тэнцвэртэй байх

4.2.2. Алслагдсан байдал: аймгийн төвөөс сум, баг хүртэлх зайд

4.2.3. Төлөв: ердийн, алслагдсан, хилийн, төв суурин, орон нутгийн хот

4.2.4. Хилийн цэс тодорхой байх

4.3. Хүн амын нутагшил суурьшил, өсөлтийн дараах үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

4.3.1. Хүн амын тоо, өсөлтийн хандлага (өсөлтийн хувь 1.05-аас дээш)

4.3.2. Иргэд суурьшин амьдрах боломжтой байх (амьдрах нөхцөл, ажлын байр, өрхийн орлого)

4.3.3. Хүн амын шилжих хөдөлгөөний татах/тулхэх хүчний харьцаа, хандлага

4.4. Эдийн засгийн бүтэц

4.4.1. Дэд бүтэц: зам тээврийн байдал, эрчим хүчний хангамж, усан хангамж, цэвэрлэх болон ариутгалын систем

4.4.2. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ; Хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан, ой, бусад); Боловсруулах үйлдвэр; төрөл бүрийн үйлчилгээ нь зэрэг тодорхой бөгөөд хоршин ажиллах боломжтой байх (мезо түвшинд кластер үүсгэж байх; ДНБ-нд эзлэх болон оруулах хувь, хэмжээ тодорхой)

4.5. Нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар

4.5.1. Эрүүл мэндийн үйлчилгээ (сум, баг, өрхийн эмнэлэг, түргэн тусламж)

4.5.2. Боловсрол (сургуулийн өмнөх, бага дунд боловсрол)

4.5.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

4.5.4. Нийгмийн бусад үйлчилгээ

4.6. Төрийн болон Нутгийн захиргааны ажил үйлчилгээ

Тус шалгуур үзүүлэлт нь Монго Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т заасан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдуулсанээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэх

зохицуулалтын эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan гэх шалгуурын нарийвчилсан зохицуулалт юм. Гэхдээ энэхүү шалгуур үзүүлэлтийг ийнхүү журамлан тогтоох боломжгүй юм. Учир нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.1-т "Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалzan тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэж зааснаар Улсын Их Хурал тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалzan гэх шалгуурыг үндэслэл болгож өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэхээр байна. Тиймээс тус шалгуурыг журмаар шийдвэрлэж болохгүй байна. Харин тус асуудал нь тус шалгуурыг шийдвэрлэх бодлогын асуудал болж байна. Тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөл буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т заасан эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалzan гэх шалгуурыг үндэслэн Улсын Их Хурал өөрийн эрх хэмжээндээ шийдвэрлэх ёстой. Бодлогоор шийдвэрлэх асуудал болон эрх зүйн хувьд шийдвэрлэх асуудлын ялгаанаас хамаарч байгаа тул энэ нь хүлээн зөвшөөрөгдөхүйц биш байна. Тиймээс уг хэсгийг хасч зохицуулах нь зүйтэй.

Нийтээр ижил ойлгох харилцааг өөр байдлаар зохицуулсан зохицуулалт болох журмын төслийн 6.5.1, 8.2 дэх хэсэг хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Журмын төслийн 6.5.1-т "Орон нутгийн байнга оршин суугч иргэдээс санал асуулга авч, дүнг гаргана.", 8.2-т "Санал хураалтад тухайн нутагт байнга оршин суугч, сонгуулийн насны иргэдийн олонх (50 хувиас дээш) оролцсон бол санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцно." гэж тус тус зохицуулсан. Тус зохицуулалтуудаас "...байнгын оршин суугч..." гэх хэсэг нь хүлээн зөвшөөрөгдөхүйц биш байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т иргэдийн саналыг авахаар заасан. Иргэдийн санал гэдгийг байнгын оршин суугч гэх зохицуулалтаар явцууруулсан нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг үгүйсгэж байна. Учир нь Иргэний хуулийн 7.2-т "Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно." гэж хуульчилсан байдаг. Энэхүү ойлголтыг нийтээр ижил ойлгодог ба үүнээс өөрөөр зохицуулсан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдал үгүйсгэгдэнэ. Тус журамд "байнгын оршин суугч" гэж явцууруулж зохицуулсан нь түр оршин суугч болон бусад хамаарах этгээдүүдийн саналыг авахгүй байх нөхцөл байдалд хүргэж хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг үгүйсгэж байна.

3.5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээд дараах хоёр асуултанд хариулахыг зорьсон.

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж,

